




СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

ТУС СУДАЛГААГ “GSP+ МЕХАНИЗМААР ДАМЖУУЛЖ ХҮНИЙ ЭРХ, ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ, МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭВ.



Улаанбаатар хот
2019 он

ГАРЧИГ

НЭГ. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ	4
ХОЁР. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ.....	6
ГУРАВ. МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН.....	6
3.1 Хууль, эрх зүйн орчин, бодлогын үнэлгээ	9
3.2 Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдал.....	22
3.3 Сэтгүүлчдийн аюулгүй байдалд хийсэн үнэлгээ	35
3.4 Сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэрхэн хөндөж байна вэ.....	51
3.5 Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх ойлголт, хэрэглээ болон сэтгүүлчийн үйл ажиллагаа, аюулгүй байдлын талаарх хуульчдын санал бодол	55
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	61
ТАВ. ЗӨВЛӨМЖ	64

НЭГ. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

“GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд Глоб интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”-ийг 2018 – 2019 онд хэрэгжүүллээ.

Тус мониторингийн хүрээнд Монгол дахь үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах, сэтгүүлчдийн аюулгүй байдал ямар түвшинд байгааг тодруулахыг зорьсон. Үүний тулд 4 төрлийн бүлэг судалгааг хийж гүйцэтгэлээ. Нэгдүгээрт, Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулсан үндсэн баримт бичиг болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 19 дүгээр зүйлийн хэрэгжилтэд 32 шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар үнэлгээ хийв. Хоёрдугаарт, “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг ашиглан Монголын сэтгүүлчдийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг сэтгүүлчдээр өөрөөр нь үнэлүүлсэн. Гуравдугаарт, Сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн хөндөж буйд дүн шинжилгээ хийлээ. Мөн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх ойлголт, хэрэглээ болон сэтгүүлчийн үйл ажиллагаа, аюулгүй байдлын талаарх хуульчдын санал бодлыг тандан судалсан болно.

Мониторингийг хэрэгжүүлсэний эцэст судалгааны баг дараах дүгнэлтэд хүрээд байна.

Монгол улс үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх болон мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөөг баталгаажуулсан олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд элсэн орж үүрэг хүлээсэн төдийгүй дотоодын суурь хуулиудыг ч баталсан байна. Гэвч дээрх эрх, эрх чөлөөнд саад болохуйц хэд хэдэн хязгаарлалтууд байна. Тухайлбал, хэдийгээр Эрүүгийн хуулиас хасагдаж, иргэний журмаар шийдвэрлэх болсон ч “Гүтгэх” хэрэг нь эрүүгийн хэрэг биш Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил болох бөгөөд, Эрүүгийн хуульд гүтгэлэгтэй төстэй зохицуулалтууд байна. Гурван сэтгүүлч тутмын нэг нь Зөрчлийн тухай хуулийн дагуу шүүх, цагдаагийн байгууллагад дуудагдаж байгаа ба 2017 он, 2018 оны эхний 3 сарын байдлаар Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлөөр 46 сэтгүүлч буруутгагдаад байгаа аж. Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргаж буй телевиз, радио, мэдээллийн сайтад тусгай зөвшөөрөл олгох, цуцлах зэрэг хязгаарлалт нь төрийн ямарваа нэгэн хэлбэрийн цензур хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавихыг хуулиар хориглосон явдлыг зөрчиж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт байна гэж үзэж байна. Сэтгүүлчдийн төдийгүй иргэдийн мэдээлэл олж авах эрхийг зөрчиж буй бас нэг эрх зүйн акт нь байгууллагын нууцын жагсаалттай холбогдон гарч ирж байна. Үүний улмаас арван сэтгүүлч тутмын долоод нь мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдол гарсан байна.

Бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод гурван сэтгүүлч тутмын хоёр нь ямар нэг хэлбэрийн сүрдүүлэг, дарамт, заналхийлэлд өртжээ. Гэвч

эрх нь зөрчигдсөн сэтгүүлчид тэр тухайгаа олон нийт, мэргэжлийн байгууллагад мэдэгддэггүй, хууль эрх зүйн мэдлэг тааруу байна. Сэтгүүлчдийн аюулгүй байдал хангалттай түвшинд биш байгаа бөгөөд ажил олгогчийн зүгээс ч тодорхой дэмжлэг байдаггүй нь судалгаанаас харагдлаа.

Энэ мэт олон хүндрэл бэрхшээл сэтгүүлчдэд тулгарч байна. Эдгээрийг даван туулахын тулд дараах арга замуудыг санал болгож байна.

Юун түрүүнд Улсын Их Хурлаас дотоодын хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын /ИБУТЭТОУП/ 19 дүгээр зүйлд нийцүүлэх шаардлагатай гэж үзлээ. Тодруулбал, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “Зарим төрлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглох” гэх 4 дүгээр бүлгийн 18-24 дүгээр зүйлийн зохицуулалт хэт ерөнхий байгааг өөрчилж, бусдад задруулахыг хориглосон мэдээллийн төрлийг мэдээлэл өгөхөөс татгалзах этгээд өөрийнхөөрөө тайлбарлах боломжийг хязгаарлах хэрэгтэй байна. Түүнчлэн Эх сурвалж хамгаалах, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах хууль зүйн баталгааг нэмэгдүүлэх шаардлага байна. Мөн төрийн байгууллага, албан тушаалтнууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах, зөрчигдөхөөс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Энэ хүрээнд Улсын Их Хурлаас Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаарх гомдлыг Комисс үр дүнтэй шалган шийдвэрлэх бүрэн эрх, хууль зүйн баталгааг бүрэн тусгах шаардлагатай байна.

Ажил олгогч байгууллага ажилтантайгаа хөдөлмөрийн гэрээ хийхдээ “Сэтгүүлчийн аюулгүй байдал”-ыг хангаж ажиллахтай холбогдуулан аюулгүй байдал зөрчигдөхөөс хэрхэн сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд хэрхэн ажиллах тухай нарийн тодорхой тусгах хэрэгтэй. Цаашлаад хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнууддаа зориулсан аюулгүй байдлын баримт бичгийг бий болгож, даган мөрдөхийг зөвлөж байна. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид аюулгүй байдал нь зөрчигдсөн тохиолдолд тухай бүрт нь зохих байгууллагуудад нь мэдэгдэж байх, ингэснээр энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, даван туулах нөхцөл бүрдэх юм.

ХОЁР. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

Мониторингийн хүрээнд дараах 4 төрлийн бүлэг судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

НЭГ. Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулсан ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлийн хэрэгжилтэд үнэлгээ хийв. Ингэхдээ нийт 38 шалгуур үзүүлэлтийн 32-г нь Монгол улсын нөхцөл байдалд тааруулан сонгон авч ажилласан болно. Эдгээр шалгуур үзүүлэлт¹ нь ХЭТТ-ийн 19 дүгээр зүйлд агуулагдаж буй үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхийн хэрэгжилтийг нарийвчлан хэмжсэн хэмжүүр болно. Шалгуур үзүүлэлтүүдийг дотор нь 2 хэсэгт хуваасан.

1. Монгол улс дахь үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх эрх зүйн орчин (хууль, журам, бодлого, шүүхийн шийдвэр)

Энэ хэсгийг Монголын хуульчдын холбоо хариуцаж ажилласан. Судалгааны хүрээнд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны гол хуулиудаас гадна 2017, 2018 онд шинээр батлагдсан хуулиудаас мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг түүвэрлэн судалсан. Түүнчлэн ЦЕГ, УЕПГ, ХЭҮК, ШЕЗ зэрэг байгууллагууд руу албан бичиг илгээж, ирсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээлэл бүрдүүлсэн.

2. Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн нөхцөл байдал (Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, хамрах хүрээ, эзэмшил, хяналт шалгалт)

Хэвлэл мэдээллийн зөвлөл мэдээлэл бүрдүүлэлт, дүн шинжилгээг гүйцэтгэсэн. ХХЗХ, ШӨХТГ, ОӨГ тэргүүтэй байгууллагуудад албан бичиг илгээж, ирсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Мөн хамаарах бүх байгууллагын веб сайтыг судалж, хайлт хийсэн. Утсаар болон биечлэн тодруулга авсан.² Холбогдох хуулиудад дүн шинжилгээ хийсэн.³

ХОЁР. ЮНЕСКО-гийн хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлт дэх “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт” -ийг ашиглан Монголын сэтгүүлчдийн аюулгүй байдлыг судлав. 8 шалгуур үзүүлэлтээр дамжуулан сэтгүүлчдийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг сэтгүүлчдээр өөрөөр нь үнэлүүлээ. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн оролцоог үнэлсэн. Судалгааны хүрээнд:

- Өдөр тутмын мэдээ мэдээлэл, эрэн сурвалжлах, нийгэм эдийн засгийн чиглэлээр бичдэг 300 сэтгүүлчийг хамруулсан санал асуулга
- Дээрх сэдвээр нарийвчилсан мэдээлэл өгч болохуйц 11 сэтгүүлчийг хамруулсан ганцаарчилсан ярилцлага

1 Шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг хавсралт 1-с харна уу.

2 Холбогдох эх сурвалжийн жагсаалтыг хавсралт 3-с харна уу.

3 Шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг хавсралтаас 2-с харна уу.

- Дээрх сэдвээр нарийвчилсан мэдээлэл өгч болохуйц 8 сэтгүүлчийг хамруулсан бүлгийн ярилцлагыг 1 удаа тус тус зохион байгуулсан.

Тус судалгааг Хэвлэл мэдээллийн зөвлөл зохион байгуулсан. Оролцогчдын түүвэр, нас хүйс, ажилладаг салбар гэх мэт мэдээллийг хавсралт 4-с үзнэ үү.

ГУРАВ. Сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр (өдөр тутмын сонин, мэдээллийн сайт) хэрхэн хөндөж буйд дүн шинжилгээ хийлээ. Хамгийн олон уншигчтай өдөр тутмын 4 сонин (Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Үндэсний шуудан) болон мэдээллийн сайтуудад тодорхой түлхүүр үгээр хайлт хийж илэрсэн бүх мэдээллийг хамруулсан. 2017 оны 3 сарын 1-нээс 2019 оны 3 сарын 16-ны өдрийг дуусталх хугацааг хамарсан.

Хэвлэл мэдээллийн зөвлөл судалгааг зохион байгуулсан. Хайлтын түлхүүр үг, мэдээллийн сайтын жагсаалтыг хавсралт 5-с үзнэ үү.

ДӨРӨВ. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх ойлголт, хэрэглээ болон сэтгүүлчийн үйл ажиллагаа, аюулгүй байдлын талаарх хуульчдын (шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуулийн ажилтан) санал бодлыг тандан судлав.

- Шүүгч, прокурор, өмгөөлөгч болон хуулийн салбарын бусад ажилтнуудыг хамарсан нийт 120 хуульчаас санал асуулга
- Дээрх сэдвээр нарийвчилсан мэдээлэл өгч болохуйц 10 шүүгчийг хамруулсан ганцаарчилсан ярилцлага
- Дээрх сэдвээр нарийвчилсан мэдээлэл өгч болохуйц 6 шүүгчийг хамруулсан бүлгийн ярилцлагыг 1 удаа тус тус зохион байгуулав.

Монголын хуульчдын холбоо судалгааг гүйцэтгэсэн. Холбогдох мэдээллийг хавсралт 6-с үзнэ үү.

Мониторингийг 2018 оны 10 сараас 2019 оны 04 сарыг дуустал хугацаанд дараах үе шатын дагуу хэрэгжүүллээ.

1. Мониторингийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай судалгааг тодорхойлсон
2. Судалгаа тус бүрийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг гаргасан
3. Баримт бичгийн судалгааг гүйцэтгэсэн
4. Судалгааны мэдээллийг бүрдүүлсэн
5. Бүрдүүлсэн мэдээллийг боловсруулж, үр дүнг гаргасан
6. Судалгаа тус бүрийн үр дүнтэй танилцаж, багаар хэлэлцсэн
7. Судалгааны үр дүнг олон улсын экспертэд танилцуулж зөвлөгөө авсан
8. Судалгааны дүгнэлтийг сайжруулж, нэгдсэн тайланг бичсэн зэрэг болно.

Мониторингийн мэдээлэл бүрдүүлэх явцад дараах хүндрэл, бэрхшээл тохиолдож байв.

- Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлгээ хийгдэж байгаагүй, эхний тохиолдол тул мэдээлэл бүрдүүлэх явц удаан хугацаанд өрнөсөн
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу мэдээлэл хүсэгч нь мэдээлэл хүсэх, авах хэлбэрийг бичгээр, амаар, утсаар гэх мэт сонгох эрхтэй. Тийм боловч төрийн байгууллагаас мэдээлэл хүсэхэд “албан бичиг”—ээр хүсэлт илгээхийг шаардаж байсан.
- Зарим индикаторын мэдээлэл нь нээлттэй боловч, хэрэглэхэд бэлэн биш боловсруулаагүй байв. Жишээ нь, телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авдаг хүн амын хувь хэмжээ, 100 хүн тутамд ногдох интернет холболттой компьютерийн тоо, 1000 хүн тутамд ногдох бүртгэлтэй интернет домайны тоо гэх мэт.
- Шүүгчид судалгаанд оролцохоос цааргалж байсан тул 10 шүүгчтэй ганцаарчилсан ярилцлага хийх байсан ч 6 шүүгч л оролцсон зэрэг болно.
- * Мониторингийн мэдээлэл бүрдүүлэх явцад цугларсан бүх мэдээллийг уг тайланд оруулаагүй. Шаардлагатай болоод сонирхолтой гэж үзсэн мэдээллийг багтаасан. Гэхдээ нийт мэдээллийг судалгааг хариуцан зохион байгуулсан байгууллага бүр мэдээллийн бааз үүсгэн хадгалж, жил бүрийн өөрчлөлтийг харьцуулан баяжуулж байхаар шийдвэрлэсэн болно.
- * Тайлангийн бүтэц: Бүлэг судалгаа бүр нь багц асуудлыг хөндсөн бөгөөд эхэн хэсэгт нь тухайн судалгааны хураангуй үр дүнг оруулсан. Дэлгэрэнгүй дүнгийн хэсэгт судалгааны асуулт, шалгуур үзүүлэлт тус бүрт хариулах байдлаар мэдээллийг өгөөд явсан. Нэмэлт мэдээллийг хавсралт хэсэгт жагсаалт хэлбэрээр дугаарлан нэгтгэсэн болно.

ГУРАВ. ҮР ДҮН

3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ

Хураангуй

- Монгол улс үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж үүрэг хүлээсэн төдийгүй, эдгээр эрхийг баталгаажуулсан Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Эрүүгийн хууль зэрэг дотоодын хуулиудтай байна.
- Дээрх хуулиудаар үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаажуулсан хэдий ч Эрүүгийн хууль, Монгол Улсын төрийн болон албаны **нууцыг хамгаалах нийтлэг журамд нууцын зэрэгтэй зүйлсийг хадгалах үүрэгтэйг** тодорхой заасан байна.
- Дайн, үймээн самуун, хүчирхийллийг өдөөн турхирсан, ялгаварлан гадуурхах үйлдэлд уриалсан аливаа сурталчилгааг хориглосон, ийм зүйл тохиолдохоос урьдчилан сэргийлэх тухай зохих хуулиудад тусгасан байна.
- Нэр төр гутаах, доромжлох үйлдэл болон гүтгэлгийг эрүүгийн хэрэгт тооцохгүйгээр иргэний хэргээр шийдвэрлэж болохоор зохицуулсан ч Зөрчлийн тухай хуульд заасан **зөрчил бөгөөд Эрүүгийн хуульд гүтгэлэгтэй төстэй заалтууд** энд үлджээ.
- Эх сурвалж хамгаалах болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалсан дотоод зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, ОНРТ-ийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тусгагдсан байна.
- Төрийн байгууллагаас ямар төрлийн мэдээлэл олж авах боломжтой тухай тусгай хуулиудаар тогтоож өгсөн байгаа бөгөөд тус эрхээ эдэлж чадаагүй тохиолдолд хараат бус механизм болох Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах боломжтой байна.
- Эрх зүйн зохицуулалтаас гадна өөрийн зохицуулалт Монгол Улсад нэгэн адил үйлчилж байна. Тодруулбал, Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын нэгдсэн хуралдаанаар 2015.04.14-ний өдөр “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг батлан мөрдүүлж байна.
- Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн хувьд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодит байдалд нийцэж байгаа буюу үнэн зөвийг нотлох үүрэгтэй байна. Гэхдээ энэ нь тэрхүү нотлох баримт буюу эх сурвалжийг нийтлэл, нэвтрүүлэгт заавал дурдах үүрэг хүлээлгээгүй байна.

- Монгол улс Радио болон телевизийн долгионыг ашиглах тэгш боломжийг нээж өгсөн, мэдээлэл олж авах эрхэд зориулсан технологийг дэмжсэн бодлоготой, бүх нийтийн боловсролыг дэмжсэн хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна.
- Монгол Улсын 100 мянган хүн тутамд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмждэг, хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг болон бүртгэлтэй төрийн бус байгууллага дунджаар 7 байна.

Дэлгэрэнгүй үр дүн

1. Гишүүн улсын соёрхон баталсан үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц

Монгол улсын хувьд үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хүний эрхийн олон улсын нийт 17 гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орж, зохих үүрэг хүлээсэн байна. Үүнээс голлох буюу үндсэн олон улсын гэрээ нь **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт юм.** (Дэлгэрэнгүйг хавсралт 7-с үзнэ үү)

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. /19-р зүйл/

2. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг үндсэн хууль эсвэл ямар нэгэн төрлийн суурь хуулиар баталгаажуулан, хүчин төгөлдөр болсон огноо болон хамрах хүрээ

Монгол Улсад үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхийг баталгаажуулсан голлох хууль нь **Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль** (1.4 дүгээр зүйлийн 4-т зааснаар “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”, 14.2 дугаар зүйлд “Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах”, 14.3 дугаар зүйлд “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” нь тус тус гэмт хэрэг байхаар зохицуулсан) юм. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 8-с үзнэ үү)

3. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай дотоодын хуулийн хүчин төгөлдөр болсон огноо болон хамрах хүрээ. Үүнд тус эрхийг хязгаарлахтай холбоотой Гишүүн улсын аливаа шийдвэрийн талаарх шүүхийн тайлбар мөн багтана.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалт болон Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 1 болон 2 дугаар зүйл нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалсан байна. Харин Эрүүгийн хуулийн 14.2, 14.3 дахь заалтууд болон Монгол улсын төрийн албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын

2, 3 дугаар зүйлүүд нь үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь **нээлттэй хэдий ч нууцын зэрэгтэй зүйлсийг хадгалах үүрэгтэй** гэдгийг харуулж байна. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 9-с үзнэ үү)

4. Нэр төр гутаах, доромжлох, гүтгэлгийг эрүүгийн хэрэгт тооцохгүй байхыг агуулсан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалсан хууль, тогтоомжийн хүчин төгөлдөр болсон огноо болон хамрах хүрээ

Нэр төр гутаах, доромжлох үйлдэл болон гүтгэлгийг эрүүгийн хэрэгт тооцохгүйгээр, Иргэний хуульд зааснаар **иргэний хэргээр шийдвэрлэж болохоор зохицуулсан**. Гэвч, “Гүтгэх” хэрэг нь эрүүгийн хэрэг биш Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил бөгөөд, **Эрүүгийн хуульд гүтгэлэгтэй төстэй зохицуулалтууд үлдсэн** байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл буюу “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт /14.8.1/ сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол 450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасан. Илт хууль бус мэдээлэл тараах гэдэг нь гүтгэхтэй төстэй байна. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 10-с үзнэ үү)

5. Эх сурвалж хамгаалахаас эхлээд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалсан дотоодын хууль хүчин төгөлдөр болсон огноо болон хамрах хүрээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 16, 17 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйл /Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах/, Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйл /Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах/ нь эх сурвалж хамгаалах болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалсан дотоодын хуулийн зохицуулалт болж байна. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 11-с үзнэ үү)

6. Мэдээлэл олж авах эрхийн талаарх хууль тогтоомжийн хүчин төгөлдөр болсон огноо болон хамрах хүрээ

Монгол Улсын Үндсэн хууль (16.17 дахь заалт), Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (2, 3 дугаар зүйл) нь мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан суурь хуулиуд болж байна. Түүнчлэн 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (11.1 дэх хэсэг), 2015 онд батлагдсан Шилэн дансны тухай хууль (4.1.4 дэх заалт), 1995 онд батлагдсан Байгууллагын нууцын тухай хууль (6 дугаар зүйл) зэрэг хуулийн хүрээнд төрийн болон төсөвт байгууллагаас гаргуулж авч болох нээлттэй мэдээллийн хүрээг тогтоож өгсөн байдаг. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 12-с үзнэ үү).

7. Хараат бус мониторингийн механизм байгуулсан огноо

2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 17.1-т “Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно” гэж заасан.

2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 3.1-т “Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага мөн” гэж заасан.

Мөн тус хуулийн 13.1-т Монгол Улсын Хүний эрхийн Комиссын бүрэн эрхэд /13.1.1/ Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах; /13.1.2/ хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах гэж заасан. Энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд Комисс нь /13.2.1/ хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулна.

8. Дайнд турхирсан суртал ухуулгыг хориглосон дотоодын хуулийн хүчин төгөлдөр болсон хугацаа болон хамрах хүрээ

2015 онд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд зааснаар аливаа дайныг өдөөхийг уриалах, сурталчилсан тохиолдолд гэмт хэрэг хэмээн үзэж, ял шийтгэл оноохоор заасан байна. Түүнчлэн эдгээр үйлдлийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн тохиолдолд ял шийтгэлийг хүндрүүлэн авч үзэхийг тусгажээ. Зар сурталчилгааны тухай хуулиар (2002) хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагааг сурталчлахыг хориглосон байдаг бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд (1998) хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөтөлбөр, агуулгад эдгээр зүйлсээс хамгаалах, урьдчилсан сэргийлэх арга замын талаар тусгах тухай тодорхой заалт орсон байдаг. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 13-с үзнэ үү)

9. Алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хориглосон дотоодын хуулийн хүчин төгөлдөр болсон хугацаа болон хамрах хүрээ

Эрүүгийн хуульд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах, үндэсний эв нэгдлийг бусниулах, террор үйл ажиллагаанд уриалах тохиолдолд гэмт хэрэг хэмээн үзэж ял шийтгэл оноохоор тусгасан. Зар сурталчилгааны тухай хуулиар (2002) хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагааг сурталчлахыг хориглосон байдаг бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд (1998) хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөтөлбөр, агуулгад эдгээр зүйлсээс хамгаалах, урьдчилсан сэргийлэх арга замын талаар тусгах тухай тодорхой заалт орсон байдаг. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 14-с үзнэ үү)

10. Үндэсний хүний эрхийн байгууллага, хүний эрхийн гомдол хүлээн авагч

эсвэл бусад төрлийн хүний эрхийн механизмуудад ирсэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаарх гомдлын шалгагдан шийдвэрлүүлсэн тоо болон Засгийн газрын зүгээс эдгээрт үр дүнтэйгээр хариу үзүүлсэн хувь хэмжээ

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албанаас Монголын Хуульчдын холбоонд 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн “Мэдээлэл ирүүлэх тухай” хариу албан бичигтээ “Хүний эрхийн үндэсний комисс 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 443 гомдол хүлээн авсан ба үүнээс үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хүрээнд хэвлэн нийтлэх эрх зөрчигдсөн тухай асуудлаар 2, жагсаал цуглаан хийх эрх зөрчигдсөн тухай асуудлаар 4, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх зөрчигдсөн тухай асуудлаар 3 гомдол байна. Харин иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг халдсан, заналхийлсэн, халдахаар оролдсон буюу улс төрийн сэдэлтээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс зүй бусаар нөлөөлсөнтэй холбоотой гомдлыг Комисст ирүүлээгүй байна” гэжээ.

Харин дээрх гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тус албан бичигт дурдаагүй ч, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн дагуу шалгаж буй гэж үзэж болохоор байна.

11. Сэтгүүлч эсвэл хэвлэл мэдээллийн аливаа хэрэгслийн ажилтнаас ирүүлсэн гомдлыг шүүх болон түүнтэй адилтгах механизмаар шалгасан, эцэслэн шийдвэрлэсэн болон баталгаажуулсан байдлын харьцаа

2015-2017 оны байдлаар (3 жилийн хугацаанд) 28 сэтгүүлч гэмт хэрэгт сэжигтнээр татагдсанаас прокурорын зүгээс 13-т нь яллах дүгнэлт үйлдэх, 15-нх нь хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргасан байна. Эдгээр сэтгүүлчдийн 14 нь эрэгтэй, мөн 14 нь эмэгтэй байжээ. Харин тус хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон нийт 70 сэтгүүлчийн 22 нь эрэгтэй, 48 нь эмэгтэй байна.

2017 он, 2018 оны эхний 3 сард Зөрчлийн хуулиар 46 сэтгүүлч шийтгүүлсэн судалгаа бүртгэгджээ.

2017, 2018 онд хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчдэд холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд зааснаар буюу “гүтгэх” гэх зүйл, хэсгээр 57 зөрчлийг шалгасан байна. “Гүтгэх” зөрчилд холбогдуулан сэтгүүлчдэд “торгох” шийтгэл оноожээ. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 15-с үзнэ үү)

12. Шүүхээс нэр төр гутаах, доромжлох, гүтгэхтэй холбоотой хэргийг хянан хэлэлцсэн болон буруутайд тооцсон шийдвэрийн хувь хэмжээ

2017.01-2018.04 сарыг хамрах хугацаанд шүүхийн шийдвэрийн цахим санд эдийн бус гэм хорыг арилгах /нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/-тай холбоотой шүүхийн нийт 49 шийдвэр байна. Үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцагчаар татагдсан 12 хэрэг байна.

- Нэхэмжлэгчдийн 4 буюу 33% нь улс төрч, төрийн удирдах албан тушаалтан, захиргааны байгууллагын албан хаагч байна.

- 12 хэргийн 6-д нь гэм хорын хохирол нэхэмжилсэн байх бөгөөд нийт 104.7 сая төгрөг, дунджаар 17.4 сая төгрөгийг нэхэмжилсэн байна.
- Шүүхийн шийдвэрийн төрлийг авч үзвэл, нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг сэргээж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, залруулга гаргахыг даалгасан 7, талуудын эвлэрлийг баталсан 4, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 1 шийдвэр байна.
- Мөн шүүхээс 75 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэм хорын хохирлыг хэрэгсэхгүй болгожээ. Харин үлдэх гэм хорын хохирлын хувьд талууд эвлэрсэн байна.

Эндээс үзэхэд, шүүхээс дараах үндэслэлийг баримталж байна. Үүнд:

- Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй /Үндсэн хууль, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ /Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1 дэх хэсэг/.
- Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэгтэй. Тодруулбал, нийтлэлдээ дурдсан мэдээллийн үнэн зөвийг, бодит байдалд нийцсэнийг баримтаар нотлох шаардлагатай. /Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэг/
- Өөр хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтлэх тохиолдолд мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягтлах үүрэгтэй. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 16-с үзнэ үү)

13. Олон нийтийн ашиг сонирхол бүхий архивын мэдээ, баримт бичиг, төрийн болон компанийн мэдээллийг /шүүхийн бүртгэл, зэвсгийн экспорт, байгаль орчны мэдээлэл, орогнол хүсэгч гэх мэт/ ил болгохоос татгалзсан хэргүүд

Тагнуулын ерөнхий газраас 2018.10.09-ний өдөр Монголын Хуульчдын холбоонд ирүүлсэн хариу албан бичигт “үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримтын жагсаалт, энэ талаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад өгсөн мэдээлэл, тохиолдол манай байгууллагад байхгүй болохыг үүгээр уламжилж байна” гэжээ. Мөн Архивын ерөнхий газраас энэ талаар ижил утгатай хариу ирүүлжээ.

14. Нэр төр гутаах, доромжлох, гүтгэхтэй холбоотой хэргийн улмаас нөхөн төлбөр авсан, цагаатгагдсан хохирогчдын хувь хэмжээ

2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний хооронд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой нийт 5 хэргийг шүүх хянан шийдвэрлэжээ.

Үүнээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан хариуцагчаар татагдсан буюу хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоотой хохирол буюу нөхөн төлбөр нэхэмжилсэн 2 хэргийг дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд:

Хүснэгт 1. Хэргийг шийдвэрлэсэн байдал

Д/д	Нэхэмжилсэн дүн /төг/	Үндэслэл	Шүүхээс шийдвэрлэсэн байдал
1	3,654,300	Нэхэмжлэгч Н-аас хариуцагч П-д холбогдуулан нэр төр, ажил хэргийн нэр төр сэргээлгэж, сэтгэл санааны улмаас учирсан хохиролд нэхэмжилсэн	Шийдвэрлэсэн байдал: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ⁴
2	10,000,000	Нэхэмжлэгч өөрийн нэр төрийг үнэлсэн байдал	Ө.О-ын нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг сэргээж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, залруулга гаргахыг "Ө.Б" ХХК-д даалгаж, 10.000.000 төгрөг гаргуулах тухай шаардлагаа баримтаар нотлоогүй гэж үзэн 10.000.000 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон. ⁵

Эндээс харахад, нэхэмжлэгч буюу хохирогчийн зүгээс нэр төр гутаах, доромжлох, гүтгэхтэй холбоотой хохирлын хэмжээг харилцан адилгүй тодорхойлж байх бөгөөд шүүхээс тэрхүү хохирлын хэмжээ баримтаар нотлогдож буй эсэхийг шууд харгалзаж байна.

4 Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.07.04-ний өдрийн 2320 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/77196/view>

5 Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.03.14-ний өдрийн 583 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/74302/view>

15. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын ёс зүйн код, баримтлах зарчим хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн огноо

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын нэгдсэн хуралдаанаар 2015.04.14-ний өдөр **"Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим"**-ыг батлан мөрдүүлж байна. Түүнчлэн www.gogo.mn мэдээллийн сайт, NTV телевиз, Eagle News телевиз зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагууд редакцийн ёс зүйн дүрмийг баталсан байдаг.

Хүснэгт 2. Ёс зүйн зарчим батлагдсан тухай мэдээлэл

№	Код, зарчмын нэр	Баталсан огноо	Баталсан байгууллага	Нэмэлт, өөрчлөлт орсон эсэх	Хүчинтэй эсэх
1	Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим	1982	МСХ-ны хорооны II бүгд хурал	-	хүчингүй
2	Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим	1996	МСХ, МЧАСЭ-ийн нэгдсэн их хурал	-	хүчингүй
3	Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим	2005.03.11	Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн II их хурал	-	хүчинтэй
4	Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	2015.04.14	Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын нэгдсэн хуралдаан	5 дугаар зүйлд ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар өөрчлөлт оруулав. 9 дүгээр зүйлд ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нэмэлт оруулав.	хүчинтэй

16. Мэдээлэл олж авах эрхэд зориулсан технологийг хөхиүлэн дэмждэг үндэсний бодлогын цаг хугацааны үечлэл болон хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 34 дүгээр тогтоолоор Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг баталсан байдаг. Тогтоолын товч агуулга нь тус бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр манай орны эдийн засгийн бүтэц сайжирч, дотоодын нийт бүтээгдэхүүнд өндөр технологийн аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин нэмэгдэнэ хэмээн өгүүлсэн байна.

17. Радио болон телевизийн долгион ашиглах тэгш боломжийг нээж өгсөн дотоодын хуулийн хүчин төгөлдөр болсон огноо болон хамрах хүрээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2, 14.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хууль болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм зэрэгт радио болон телевизийн долгионыг ашиглан үзэл бодлоо илэрхийлэх

боломжийг зохицуулж өгсөн байдаг. (Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралт 17-с үзнэ үү)

18. Бүх нийтийн боловсролын талаарх үндэсний бодлогын хугацааны үечлэл болон хамрах хүрээ

Бүх нийтийн боловсролыг дэмжих зорилгоор дараах хөтөлбөрүүдийг баталсан байдаг.

Хүснэгт 3. Бүх нийтийн боловсролыг дэмжих хөтөлбөрүүд

№	Бодлого, хөтөлбөрийн нэр	Огноо	Дугаар	Хамрах хүрээ
1	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай	2004 оны 12 дугаар сарын 22-ны өдөр	244/Засгийн газар	
2	Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр/	1995 оны 2 дугаар сарын 6-ны өдөр	19/Засгийн газар	
3	“Боловсрол” үндэсний хөтөлбөр	2010 оны 2 дугаар сарын 3-ны өдөр	31/Засгийн газар	2010-2021
4	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай	2015 оны 01 сарын 29 өдөр	12/УИХ тогтоол	2014-2024
5	Тогтвортой хөгжлийн боловсрол Үндэсний хөтөлбөр	2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр	209/УИХ	

19. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмждэг, хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг болон бүртгэлтэй төрийн бус байгууллагын тоо /100 мянган хүн тутамд/

Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хүний эрх болон хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг **241 төрийн бус байгууллага** байна. Үүнээс 2018 оноос бүртгүүлсэн төрийн бус байгууллага 20 байна.

Эндээс харахад, Монгол Улсын 100 мянган хүн тутамд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмждэг, хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг болон бүртгэлтэй төрийн бус байгууллага дунджаар 7 байна.

Мөн нэрэндээ хэвлэл мэдээлэл, сэтгүүлч, мэдээлэл гэх үг хэрэглэсэн төрийн бус байгууллагын тоо 32 байна.

20. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ: Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдох иргэний хэргийн шүүхийн шийдвэр

№	Шүүх	Огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Хэргийн агуулга/ Шийдвэрийн утга	Нотлох баримтын үнэлэлт	Хууль зүйн үндэслэл
1	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2018-03-14	Ө.О - "Геологийн төв лаборатори" ТӨААТҮГ-ын захирал	Сэтгүүлч Х.Баатар, шуурхай.мн сайт	Нэр төр гутаасан мэдээллийг няцааж, нэр төр сэргээлгэх	1.2017.06.07-ны өдөр www.shuufai.mn сайтад "Ө-О-г эрүүлэн татах уу" нэртэй нийтлэл гарсан. Уг нийтлэлд "Геологийн төв лабораторид МАН-ын Удирдах зөвлөлийн шийдвэрээр томилогдон очсон Ө.О тус шийдвэрээр томилогдон очсон Ө.О тус айлыг самарч байгаа", "ажлын дадлага туршлага, мэдлэг боловсрол дутсан уу", "бүтцийн өөрчлөлт нэрээр ажилтныг хууль бусаар халсан", "шахах дарамтлах маягаар хууль бус хурал зохион байгуулсан" гэх зэргээр бичигджээ. 2. Нийтлэлд Ө.О-ын нэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсныг сэргээж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийж, залруулга гаргахыг "Ө.Б" ХХК-д даалгаж, нэхэмжлэлээс үлдэх 10 сая төгрөгийг хэрэгсэхгүй болгосон	-Цахим хуудсанд гарсан нийтлэл, түүний агуулга -Цахим хуудсыг эрхлэн гаргагчийн мэдээлэл -Хариуцагчийн алдаагаа зөвшөөрсөн тайлбар -Нэхэмжлэгч эдийн бус гэм хорын хохирол гаргуулах шаардлагаа баримтаар нотлоогүй	Иргэний хуулийн 21.2, 497.1
2	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017-07-27	Үлэмжгросер с-ХХК	Факт.мн сайт – Б.Мөнхзул	Ажил хэргийн нэр хүндийг гутаасан болохыг тогтоож, гутаасан мэдээ тараасан хэлбэр, хэрэгслээр залруулга няцаалт	1.Факт.мн сайт нь 2016.12.16-ны өдөр "Гүүд прайс маркет хугацаа нь дууссан бүтээгдэхүүн худалдаж байна" гэсэн гарчиг бүхий мэдээллийг нийтэд түгээсэн 2."Үлэмжгросерс" ХХК-ийн ажил хэргийн нэр хүндийг сэргээж, хариуцагч Б.М-д Факт.мн сайт, Факт.мн фэйсбүүк хуудсаар няцаалт хийхийг үүрэг болгож, нэхэмжлэгчийн шаардлагаас хариуцагч "ОХ" ХХК, Факт.мн сайтад холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгосон.	-Зохигчдын тайлбар, -хэрэгт авагдсан сайтын болон факт.мн фэйсбүүк хуудсанд хийсэн үзлэгийн тэмдэглэл, -гэрчүүдийн мэдүүлэг -вэб сайт дангаараа хариуцагч болохгүй -вэб сайтыг эзэмшдэг, удирдан явуулдаг этгээд хариуцлага хүлээнэ	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1; Иргэний хуулийн 27.6, 21.2

№	Шүүх	Огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Хэргийн агуулга/ Шийдвэрийн утга	Нотлох баримтын үнэлэлт	Хууль зүйн
3	Хан-Уул дүүргийн Иргэний анхан шатны шүүх	2017-06-02	Ц.Оюундарь	1.Ч.Батцэн гэл 2. МҮОНРТ	Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд сэргээлгэх, хууль бус мэдээллийг няцаалгах	1.“МҮОНРТ-ийн ажиллагсдын түр хороо”-ны “МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд “Шаардлага хүргүүлэх тухай” гэсэн мэдээлэл”-ийг 2016.11.08-ны “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн 20 цаг 16 минутаас 20 цаг 21 минутын хооронд “Шуурхай мэдээлэл” нэртэйгээр нэвтрүүлсэн нь Иргэн Ц.Оюундарийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан эсэх тухай 2.Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	-Цацагдсан мэдээллийн талаар талууд маргаагүй -Цацагдсан мэдээллийн CD-ний бичлэг, түүнд үзлэг хийсэн тэмдэглэл -Мэдээллийн эх сурвалжийг “МҮОНРТ-ийн ажиллагсдын түр хороо” гэж холбогдох мэдээлэлд заасан тул Ц.Б-ийн хувьд уг мэдээлэл, нийтлэлийн үнэн зөв эсэхийг хариуцах хууль зүйн үндэслэлгүй	Иргэний хуулийн 21.2, 21.3, 21.9, 497.1, 511.1 Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 9.3, 9.4
4	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017-06-23	Норовын Алтанхуяг	Өглөөний сонин ХМХ	Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэх	1.Өглөөний сонины 2016.12.12-ны өдрийн дугаарт “Оюу толгойд шатахуун шахсан уу” гэх гарчигтай нийтлэл цацаж, уг нийтлэлээ өөрийн эрхлэн ажиллуулдаг www.mongnews.mn сайтаа нийтэлж олон нийтэд тараасан гэх хэрэг. 2.Нэхэмжлэгч нь Н.Алтанхуягийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсаны улмаас учирсан хохиролд 10 сая төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагаа 8 сая төгрөгөөр багасгаж үлдэх 2 сая төгрөгийг хариуцагч нь 2017.10.31-ний дотор төлж бариадуулах, Н.Алтанхуягийн нэр төрийг сэргээн, худал мэдээлэл тараасан хэлбэр хэрэгслээрээ залруулга хийж Өглөөний сонины 2017.07.03-ны дугаарын нүүр	-Эвлэрлийн гэрээ, тус гэрээний нөхцөл буюу талуудын тохиролцоо	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.5., 123.1

№	Шүүх	Огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Хэргийн агуулга/ Шийдвэрийн утга	Нотлох баримтын үнэлэлт	Хууль зүйн
5	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017-01-12	Х.Сэлэнгэ	Эдмүүн ХХК – Zaluu.com	10 Өөрийнх нь талаар нийтэлсэн мэдээ, нийтлэл, гэрэл зургийг устгуулж, мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаалт хийлгэх, хэвлэлийн бага хурал хийлгэж, уучлалт гуйлах	хуудаст болон www.morningnews.mn сайтын харагдах өнцөгт байршуулахаар харилцан тохиролцож эвлэрсэн зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон. 1.2016.11.21-ний өдөр өөрийн эрхэлдэг Zaluu.com /www.zaluu.com/ цахим хуудаст нийтэлсэн “Н.Алтанхуягийн эхнэрийн дансанд их хэмжээний мөнгө шилжиж оржээ” гэсэн нийтлэл, холбогдох гэрэл зураг 2.Нийтлэл, зургийг устгах, уг цахим хуудсаар дамжуулан иргэн Х.Сэлэнгэс уучлалт гуйх, уг нийтлэлтэй холбоотой мэдээлэлд залруулга хийх, няцаалт өгөх, залруулга, няцаалтыг Zaluu.com /www.zaluu.com/ цахим хуудаст 2 сар 4 хоногийн хугацаанд байршуулахыг хариуцагч “Эдмүүн” ХХК-д даалгаж, үлдэх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон.	-Цахим хуудаснаас хэвлэсэн гэх нийтлэлүүдийг шүүх үзлэгээр бэхжүүлээгүй бөгөөд маргаагүй үйл баримтыг шүүх нотлох шаардлагагүй гэж үзсэн -Талуудаас гаргаж өгсөн нийтлэлүүд үг, үсэг, утга агуулгын хувьд адил -Талуудын тайлбар -нийтлэлийг бичгийн нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжтой - Хариуцагч нийтлэлийнхээ үнэн зөвийг нотолж чадаагүй -Сэтгэл санааны хохирлын хэмжээг хэрхэн тооцож гаргасан нь тодорхойгүй байх тул уг шаардлагыг хэрэгсэхгүй болгох	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1, Иргэний хуулийн 21.2

Дээр дурдсан 2017, 2018 оны иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

А. Хууль зүйн үндэслэл

Шүүхээс дүгнэлт хийх, шийдвэр гаргахдаа Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн

- 21.2 дахь хэсэг */Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ/,*
- 21.3 дахь хэсэг */Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ/,*
- 21.9 дэх хэсэг */Энэ зүйлд заасан эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу сонирхогч этгээдэд энэ хуулийн 497, 511 дүгээр зүйлд заасан журмын дагуу арилгана/,*
- 497.1 дэх хэсэг */Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй/,*
- 511.1 дэх хэсэг */Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ/ болон*

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг */Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй./-ийг нийтлэг байдлаар үндэслэл болгож байна.*

Эндээс харахад, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн хувьд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодит байдалд нийцэж байгаа буюу үнэн зөвийг нотлох үүрэгтэй байна. Гэхдээ энэ нь тэрхүү нотлох баримт буюу эх сурвалжийг нийтлэл, нэвтрүүлэгт заавал дурдах үүрэг хүлээлгээгүй байна.

Б. Нотлох баримт, түүний үнэлгээ

Шүүхээс тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулга болон түүнд хамаарах нотлох баримтыг дүгнэх замаар шийдвэр гаргаж байна. Ингэхдээ 1/ тухайн нийтлэл, нэвтрүүлгийг бичсэн буюу хариуцах этгээдийг тодруулах, 2/ агуулгын талаар талуудын хооронд ойлголтын зөрүү бий эсэхийг тодруулах, 3/ нийтлэл, нэвтрүүлгийг үзлэгийн тэмдэглэл, талуудын тайлбар зэргээр бэхжүүлж, нотлох баримтад тооцох, 4/ сэтгэл санааны хохирол учирсан эсэх, хохирлын хэмжээг хэрхэн тооцсон эсэх талаар нотлох баримт бий эсэхийг тус тус харгалзаж байна.

3.2 МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хураангуй

- Монгол улсад сонин, сэтгүүл, радиогоос илүүтэй телевиз, интернет хэрэглэгчдийн хувь хэмжээ өндөр байдаг аж. 2018 оны эхний байдлаар 434 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдний дийлэнх болох 78 хувийг нь хувийн компани, хувь хүн эзэмшдэг. Хамгийн хүртээмжтэй 4 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тутмын 3 нь улс төр, бизнесийн ямар нэгэн ашиг сонирхол дор оршдог.
- Сонины нийт борлуулалтын хэмжээ жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна. Сонины нийт борлуулалтын 84 хувийг захиалгаар, 16 хувийг үүргээр буюу өдөр тутмын худалдаагаар борлуулдаг ажээ.
- Телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авдаг хүн амын хувь хэмжээ тодорхой бус ч технологийн хувьд орон даяар болон дэлхий дахинд түгээх боломжтой байна.
- Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн дагуу МҮОНТ үндэсний цөөнхөд зориулсан мэдээллийн хөтөлбөрийг тува, буриад, казах хэлээр бэлтгэн хүргэдэг. Баян-өлгий аймагт казах хэлээр гардаг 1 сонин, 1 сэтгүүл, 1 радио ажиллаж байгаа нь үндэсний цөөнхөд зориулсан эх хэлээр нь нийтлэгддэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болно.
- Монгол Улсын Үндсэн хуульд аливаа нэг шашныг онцолж, төрийн болон үндэсний шашнаар өргөмжлөөгүй байдаг ч Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бурхны шашныг онцгойлж дэмжих тухай заасан байдаг. Улмаар “Бурханы шашны” гэх тодотголтой ТВ9 телевиз “ашгийн бус, шашны суваг” хэмээн тусгай зөвшөөрлөө авсан ч улс төрийн ашиг сонирхол, хамаарал бүхий болсныг судалгаа, мэргэжилтнүүдийн дүгнэлт харуулдаг.
- Монгол улсад хүйн хэвлэл мэдээллийг дэмжсэн төрийн бодлого эрх зүйн дэмжлэг байхгүй, цаашлаад арилжааны радио, телевиз байгуулахад тавигддаг шаардлагыг шалгуур болгодог зэрэг нь дотоод, гадаадын олон улсын байгууллагын тусламжтайгаар үүсгэн байгуулсан хүйн хэвлэл мэдээллийг ажиллах боломжгүйд хүргэж байна.
- Орчин цагт хурдтайгаар мэдээлэл авах, түгээх боломжийг хэмжих шалгуур болох 100 хүн тутамд ногдох интернет холболттой компьютерийн тоо, 1000 хүн тутамд ногдох бүртгэлтэй интернет домайны тоо зэргийг тодорхой тооцох боломжгүй, зохицуулалт дутмаг байна.
- Монгол улсад хараат бус өрсөлдөөний комиссын үүрэг бүхий байгууллага болох Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нэгдэл болон худалдан авалтыг байгууллага, иргэдээс гомдол, хүсэлт ирсэн тохиолдолд шалгах

боломжтой бөгөөд сүүлийн 2 жилд үүнтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

- Харилцаа холбооны зохицуулах хороо нь телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг, кабелийн сувгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох тохиолдолд ШӨХТГ-ын шийдвэрийг үндэслэдэг бол бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг шинээр нээх, худалдаж авахад тусгайлсан ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлагагүй. Харин хуулийн дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх ба тийнхүү бүртгүүлэх үйл явцад мэдээллийн хэрэгслийн эзэн, түүний зах зээлд эзлэх хувь, бизнесийн бусад төрөлд эзэмшиж буй хэмжээ зэрэг нь хамааралгүй байдаг.
- Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар болон Цагдаагийн байгууллага өөрсдийн хамаарах хүрээнд дүгнэлт гаргах бөгөөд түүнд нь үндэслэн радио, телевиз, цахим сайтын хандалтыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалтуудыг Харилцаа холбооны зохицуулах хороо эрхэлдэг. Гэвч тус хязгаарлалт нь нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготой боловч нэр томьёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүй юм.
- Соёлын тухай хууль болон Сонгуулийн тухай хуульд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тусгасан байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт гэж үзэж байна.
- Гүтгэх, доромжлох асуудлыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх болсонтой холбогдуулан цагдаагийн ажилтан сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хориглох, саад болох тохиолдол илэрч байна. Сэтгүүлчийг бүтээлээ цацахгүй байхыг сануулах, зөрчилтэй асуудлаар нийтэлж, нэвтрүүлэхгүй байхыг ятгасан тохиолдол гарсан байна.
- Мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хууль болох Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд хангалтгүй үнэлгээг авсан байна.
- Сэтгүүлч, хүний эрх хамгаалагч эсвэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэн хэн нэгэн алуулсан, алга болсон болон хоригдсон тохиолдол Монгол улсад гараагүй ч сэтгүүлчийг сүрдүүлсэн дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, ажлын багаж хэрэгсэлд халдсан, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан, нийтлэл нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон гэх мэт тохиолдлууд гарсан хэвээр байна.

Дэлгэрэнгүй үр дүн

21. Сонин, сэтгүүл, радио, телевиз, интернетийн сайт эзэмшигчдийн тоо/ төрийн болон хувийн/ болон уншигч үзэгчдийн тоо

2018 оны эхний байдлаар Монгол улсад 88 сонин, 71 сэтгүүл, 48 радио, 127 телевиз, 100 мэдээллийн сайт тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хэвлэл мэдээллийн байгууллагуудын дийлэнх буюу 78 хувийг хувийн компани, хувь хүн эзэмшиж байгаа аж.⁶

Хүснэгт 4. Хэвлэл мэдээллийн эзэмшил

	Сонин	Сэтгүүл	Радио	Телевиз	Мэдээллийн сайт
Хувийн байгууллага	72%	63%	78%	91%	92%
ТББ, иргэний холбоод	11%	25%	10%	6%	6%
Улс төрийн нам/эвсэл	2%	0%	0%	0%	0%
Төрийн байгууллага	15%	12%	12%	3%	2%
Нийт	100%	100%	100%	100%	100%

Хэвлэлийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр” тайланд дурдсанаар гурав болон түүнээс дээш хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшдэг 8 байгууллага бий бөгөөд энэ нь нийт мэдээллийн хэрэгслийн 10 орчим хувийг хамардаг байна. (Дэлгэрэнгүйг тус тайлангаас үзэх боломжтой) Хэдийгээр энэ тоо нь Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд харьцангуй бие даасан байдалтай мэт харагдуулж байгаа ч нарийвчилсан судалгааны дүн өөр дүр зургийг өгүүлдэг.

Хэвлэлийн хүрээлэн 2016 онд Хил Хязгааргүй Сэтгүүлчид олон улсын байгууллагатай хамтран “Монголын хэвлэл мэдээллийн эзэмшил” судалгааг хэрэгжүүлсэн байна. Тус судалгаанд хамгийн их хүртээмжтэй, өндөр рейтингтэй 39 хэвлэл мэдээллийн байгууллагыг хамруулсан бөгөөд тэдний 74 хувь нь улс төр, бизнесийн ашиг сонирхлын ямар нэгэн хамааралтай байгааг олж тогтоожээ. Судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolia.mom-rsf.org/mn/ хаягаар үзэх боломжтой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн мэдээллийг шууд олж авахад хүндрэлтэй байдаг. Телевиз, радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Харилцаа холбооны зохицуулах хорооны <http://www.crc.gov.mn> сайтаас үзэх боломжтой ч хувь эзэмшигчдийн хэмжээ тодорхой бус байдаг. Сонин, сэтгүүлийн эзэмшигчдийн мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамаарагддаг бөгөөд ил тод бус. Мэдээллийн сайтыг нэгдсэн журмаар, албан ёсоор бүртгэдэггүй, ХХЗХ-нд байх бүртгэл нь сайн дурын шинжтэй байдаг.

6 Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр”, Хэвлэлийн хүрээлэн, 2018 он

ХХЗХ-ноос интернет хэрэглэгчдийн тоог албан ёсоор гаргадаг бөгөөд 2018 оны эцсийн байдлаар Монгол улсад давхардсан тоогоор 4295400 орчим хүн интернет хэрэглэж байна.⁷ Эдгээр интернет хэрэглэгчдийн 72 хувь нь өдөр бүр ямар нэг хэмжээгээр интернетэд холбогдож буй бөгөөд 34 хүртэлх насныхан илүүтэй жин дарж байна. Газарзүйн байршлаар ангилж харвал Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 80 хувь, хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн 66 хувь нь интернетэд өдөр бүр холбогддог аж.⁸

Сонин, сэтгүүлийн уншигчид болон телевиз радиогийн үзэгч, сонсогчдын тоог ХХЗХ болон бусад байгууллагаас тооцож гаргадаггүй. Харин хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн хүртээмж, хэрэглээний байдлыг түүвэр судалгааны дүнд үндэслэн гаргадаг. 2018 онд Хэвлэлийн хүрээлэнгээс үндэсний хэмжээнд 1000 хүнийг хамруулан хийсэн судалгаагаар тус судалгаанд оролцогчдын тал нь сонин огт уншдаггүй гэжээ. Улаанбаатар хотоос оролцогчдын 7 хувь нь, хөдөө орон нутгийн оролцогчдын 3 хувь нь л өдөр бүр сонин уншдаг байна.

Сэтгүүлийн тухайд ч мөн судалгаанд хамрагдагсдын тал хувь нь огт уншдаггүйгээ илэрхийлсэн. Өдөр бүр унших тохиолдол байхгүй, харин 10 орчим хувь нь 7 хоногт нэг удаа уншдаг гэжээ. Сонин, сэтгүүл уншигчдын хувь хэмжээ жил ирэх тусам буурч байгааг тус судалгаанд мөн дурдсан байна.

Тус судалгаанд дурдсанаар таван хүн тутмын гурав нь радиог огт сонсохгүй байна. Өдөр бүр радио сонсдог иргэд Улаанбаатар хотод 11 хувь, орон нутагт 6 хувьтай байгаа аж. Харин телевизийн тухайд сонин, сэтгүүл, радиогоос илүүтэй хүртээмжтэй суваг байна. Улаанбаатар хотын оролцогчдын 77 хувь, орон нутгийн оролцогчдын 80 хувь нь телевизийг өдөр тутам үздэг нь судалгаагаар харагджээ.


22. Үндэсний болон бүс дундын сонинуудын захиалагчдын тоо болон өдөр тутмын худалдаа

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2018 оны эхний байдлаар 88 сонин үйл ажиллагаа явуулж байжээ. 88 сонины нийт борлуулалтын хэмжээ 2017 оны байдлаар 14,092,900-р тоологдсон байна. Сонины нийт борлуулалтын 84 хувийг захиалгаар, 16 хувийг үүргээр буюу өдөр тутмын худалдаагаар борлуулдаг ажээ. Сонины нийт борлуулалтын хэмжээ жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна.

7 Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

8 “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр”, Хэвлэлийн хүрээлэн, 2018 он

График 1. Сонины борлуулалтын хэмжээ



Сонины захиалга нь шуудан компаниудаар дамжуулж болон редакцияс шууд захиалах хэлбэрээр хийгдэж байна. Түүнчлэн цахимаар сонин захиалж унших мөн хамаарч байна.

23. Телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авдаг хүн амын хувь хэмжээ

Телевиз, радиогийн нэвтрүүлэг хүлээн авдаг хүн амын хувь хэмжээг албан ёсоор гаргадаггүй. Гэхдээ өргөн нэвтрүүлгийн 16 телевиз радио давтамж ашиглан нэвтрүүлгээ орон даяар цацдаг. (Телевизийн төхөөрөмжтэй өрх бүр хүлээн авах боломжтой)

Монгол улсын хүн амын тоо 2018 оны эцэст 3,208,189 байв.⁹

Мөн хиймэл дагуул, кабель болон IPTV-н тусламжтайгаар (телевизийн олон сувгийн үйлчилгээ) эдгээр 16 сувгаас гадна дотоодын 52+ сувгийг орон даяар хүлээн авах боломжтой. Телевизийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчийн тоо 2018 оны эхний хагас жилийн байдлаар 916 600 байна. Нийт хэрэглэгчдийн 5 хувь нь кабель, 44 хувь нь хиймэл дагуул, 30 хувь нь IPTV, 21.1 хувь нь DTV-ээр хүлээн авч байна.¹⁰

Түүнчлэн 14 телевизийн сувгийг өөрийнх нь веб сайтаар дамжуулан, www.looktv.mn веб сайтаар дамжуулан 27 Монгол сувгийг интернетээр, дэлхий даяар хүлээн авах боломжтой байна.

Радиогийн тухайд, Монголын үндэсний олон нийтийн радио, Лавайн эгшиг радио, Шинэ монгол радио зэрэг гурван радио үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацаж байна. 11 радиог онлайнаар шууд сонсох боломжтой байна. Түүнчлэн 8 радиог ухаалаг утасны аппликейшн ашиглан сонсож болно. МҮОНР-г фэйсбүүк дэх MNB Live-аар дүрстэй үзэх боломжтой.¹¹ Харилцаа холбооны зохицуулах хорооны веб сайтад радиогийн олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчдийн тоо тавигдаагүй байна.

9 Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

10 Харилцаа холбооны зохицуулах хороо, www.crc.gov.mn

11 "Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр", Хэвлэлийн хүрээлэн, 2018 он

24. Төрөөс дэмжсэн болон хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үндэстний, шашны болон хэлний цөөнхийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо

2005 онд батлагдсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 8.2.7-д “Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараах бодлого баримтална” хэмээгээд “...Үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх” ёстойг тусгасан байдаг. МҮОНТ 2011 оноос үндэстний болон хэлний цөөнхөд зориулж тува, буриад, казах хэлээр мэдээллийн хөтөлбөр бэлтгэн түгээдэг болсон. Тус мэдээллийн хөтөлбөр нь өргөн нэвтрүүлгийн сувгаар бус МҮОНРТ-ийн хоёрдугаар суваг болох кабелийн сувгаар (Монголын мэдээ суваг) олон нийтэд хүрч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд аливаа нэг шашныг онцолж, төрийн болон үндэсний шашнаар өргөмжлөөгүй байдаг. Гэхдээ Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4.8-д “Уламжлалт Бурхны шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ.”, 3.1.4.9-д “Монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурхны шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжинэ.” гэсэн заалтууд бий.

“Бурханы шашны” гэх тодотголтой ТВ9 телевиз “ашгийн бус, шашны суваг” хэмээн тусгай зөвшөөрлөө авсан байдаг. Гэвч хөтөлбөрийн бүтэц дэх бурханы шашны холбогдолтой мэдээ, нэвтрүүлгийн хувь хэмжээ тодорхой бус, улс төрийн ашиг сонирхол, хамаарал бүхий болсныг судалгаа¹², мэргэжилтнүүдийн дүгнэлт харуулдаг.

Бурханы шашны үзэл санааг түгээдэг нэг суваг нь Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх “Лавайн эгшиг радио” юм.

Үндэстний, шашны, хэлний цөөнхийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн асуудлыг хөндөхдөө хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг заавал чухалчилж авч үзэх хэрэгтэй. Монгол улсад хүйн хэвлэл мэдээллийг дэмжсэн төрийн бодлого, эрх зүйн дэмжлэг байхгүй бөгөөд Засгийн газраас ч энэ чиглэлд таатай орчин бүрдүүлэх, тэдэнд санхүүгийн болоод бусад төрлийн туслалцаа үзүүлэх талаар анхаардаггүй, хүйн хэвлэл мэдээлэлд зориулсан зурвас долгион байхгүй. Орон нутгийн болон хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих төрийн тусгай сан, санхүүгийн нөөц байдаггүй. Цаашлаад, ХХЗХ-ны журмаар үүнийг зохицуулаагүйгээс арилжааны радио, телевиз байгуулахад тавигддаг техникийн үзүүлэлт, мэргэжлийн боловсон хүчин, нэг өдрийн нэвтрүүлгийн хамгийн доод хугацаа, орлого зэрэг өндөр шаардлагууд хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд адилхан үйлчилдэг нь тэдэнд саад бэрхшээл болж байна. Гэхдээ эдгээр саад бэрхшээлийг

12 <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-media/detail/outlet/tv9/>

үл харгалзан, хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулахыг хориглоогүй тул хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах оролдлогыг ихэнх тохиолдолд олон улсын донор байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар хийсэн байдаг.

2012 онд “Хүйн радиогийн тогтвортой байдлыг дэмжих” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд Глоб интернэшнл төрийн бус байгууллага нь МҮОНР, Радио, телевизийн сүлжээний газартай хамтран Ховд, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл гэсэн дөрвөн аймгийн алслагдсан арван суманд хүйн радиог байгуулсан юм. Энэ үед Монголын Хүйн радиогийн холбоог байгуулсан төдийгүй, 2015 онд Дэлхийн хүйн радиогийн холбооны гишүүн болсон түүхтэй. Эдгээр нь:

1. Ховд аймгийн Алтай суман дахь “Бодончийн долгион” радио
2. Баян-Өлгий аймгийн Толбо суман дахь Толбо нуур /Мендикол/ радио
3. Баян-Өлгий аймгийн Буянт суман дахь “Хөлцөөтийн цуурай” радио
4. Баян-Өлгий аймгийн Улаан-Хус суман дахь “Улаан-Хусын долгион” радио
5. Баян-Өлгий аймгийн Баяннуур суман дахь “Уушигтын цуурай” радио
6. Увс аймгийн Зүүнговь суман дахь “Өгөөмөр аялгуу” радио
7. Увс аймгийн Тэс суман дахь “Таван Тэсийн Долгион” радио
8. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суман дахь “Хотгойдын дуу хоолой” радио
9. Хөвсгөл аймгийн Цагаан-Нуур суман дахь “Тайгын Аялгуу” радио
10. Хөвсгөл аймгийн Улаан-Уул суман дахь “Шишигтийн дуу хоолой” радио

Дээрх арван хүйн радиогийн тогтвортой байдлыг бий болгох зорилгоор хэд хэдэн удаагийн сургалт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, үлгэрчилсэн дүрэм, гарын авлага зэргийг гаргасан боловч үйл ажиллагаа саармагжсан байна.

ЮНЕСКО, Глоб интернэшнл төвтэй хамтран 2019 эхний хагас жилд Хүйн хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын суурь судалгааг хийж, Монголын хүйн радиог бэхжүүлэх нь төслийн зөвлөлдөх уулзалтын хүрээнд энэ талаар танилцуулсан. Судалгаанаас үзэхэд боловсон хүчний дутагдалтай байдал, Засгийн газар, орон нутгийн удирдлагын дэмжлэг дутмаг, радиогийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл дууссан гэх зэрэг хүчин зүйлээс шалтгаалан дээрх радиогийн үйл ажиллагаа зогссон байна. Мөн Баян-Өлгий аймгийн Толбо суман дахь радиогийн байр шатсан байна. Гэсэн хэдий ч Хөвсгөл аймгийн Улаан уул, Цагаан нуур, Цагаан уул суманд байрлах радио Ховд аймгийн Алтай сумын

“Бодончийн долгион” гэсэн нийт дөрвөн радиогийн үйл ажиллагааг бүрэн сэргээх боломжтой байна. Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүйн радио нь өнгөрсөн оны 5 дугаар сар хүртэлх хамгийн идэвхтэй, сайн ажиллаж ирсэн байна. Тогтмол 1000 гаруй сонсогчтой бөгөөд 10-19 цаг хүртэл ажиллаж байсан Монголын хүйн радиогийн холбооны ерөнхийлөгч Ц.Оюунтунгалаг мэдэгдсэн юм. Түүнчлэн орон нутгийн иргэд хүйн радиогийн идэвхтэй сонсогчид байж чаддаг байна. Иргэд сумынхаа Засаг Даргын шийдэр төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэл, гомдол шийдвэрлэсэн байдал болон ИТХ-ийн хурлыг радиогоор шууд хүлээн авах хүсэлтэй байгаа. Тэдэнд шаардлагатай мэдээллээс нэрлэвэл сумын Хөгжлийн сан, банк, нийгмийн даатгал, тэтгэмж, хуулийн зөвлөгөө, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал, гэр бүлийн хүчирхийлэл, архи тамхитай тэмцэх тухай, эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл авах хүсэлтэйгээ илэрхийлсэн байна. Сурагчдад танин мэдэхүй, орон нутгийн түүх соёл, домог, гадаад хэлний тухай мэдээлэл хэрэгтэй талаар судалгааны явцад ярилцсан байна.

25. Хэлний цөөнхүүд өөрийн хэл дээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгаа хувь хэмжээ

Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох, хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий бүлэг хүнийг хэлнэ. Шашны цөөнх, хэлний цөөнх гэх зэрэг ойлголтууд үндэсний цөөнх гэдэг нэр томъёонд хамаарч явах буюу түүнээс салбарлаж хэрэглээнд ордог.¹³

Монгол улсын хэмжээнд үндэстний цөөнхийн хамгийн том төлөөлөл бол казах (хасаг), цаатан (духа), тувачууд мөн. Монгол Улсын суурин хүн амын 84.5 хувийг Халх үндэстэн, 3.9 хувийг Казах, 2.4 хувийг Дөрвөд, 1.7 хувийг Баяд, 1.3 хувийг Буриад ястан эзэлж байгаа нь улсын нийт хүн амын 94 орчим хувь болж байна.¹⁴

2011 оноос МҮОНТВ-ээр тува, буриад, казах гэсэн гурван хэлээр 10 минутын урттай мэдээллийн хөтөлбөр долоо хоногт нэг удаа гарах болсон. Одоогийн байдлаар МҮОНРТ-ийн “Монголын мэдээ” сувгаар буриад, казах хэлээр тус бүр долоо хоногт таван удаа 15 минутын урттай буюу нийт 30 минутын урттай мэдээллийн хөтөлбөр гарч байна. Энэ нь ойролцоогоор нийт эфирийн цагийн 5.6 хувийг хувийг эзэлж байна. Түүнчлэн МҮОНТ нь цаг үеийн мэдээллийн хөтөлбөрт сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлийг давхар ашигладаг.

Баян-Өлгий аймгийн хувьд нийт 99,346 хүн амтай, үндэстэн ястны 29 төлөөлөл оршин суудаг ба нийт хүн амынх нь 88.7 хувийг казахууд эзэлдэг байна. Тус аймагт үйл ажиллагаа явуулж буй Монгол Заман сонин, Дербес ТВ, Саяан ТВ, ТВ 4 зэрэг телевизүүд, Өлгий ньюс мэдээллийн сайт зэрэг мэдээллийн хэрэгслүүд бий бөгөөд казах, монгол хэлээр гардаг байна. Харин Жана дауир сонин, Шугыла сэтгүүл,

13 Хүний эрхийн үндэсний комисс, http://www.nhrm.gov.mn/media/documents/1365587476_2012_10_06_minority_right.pdf

14 үндэстний цөөнхийн эрхийн асуудал, УБ 2018, Монгол Улсын хүний эрхийн комисс, Чинагийн Галсан сан

Орон нутгийн олон нийтийн Казах радио нь казах хэлээр дагнан мэдээлэл хүргэдэг байна.

26. 100 хүн тутамд ногдох интернет холболттой компьютерийн тоо

Үндэсний статистикийн хорооны мэдээлж буйгаар 2018 оны байдлаар 1000 хүн тутамд ногдох компьютерийн тоо 202 байна. Үүнээс мониторингийн шалгуур үзүүлэлтийн дагуу 100 хүн тутамд ногдох компьютерийн тоог гаргавал 20.2 болж байна. Харин интернет холболттой компьютерийн тоог тодорхой бус байна.

27. 1000 хүн тутамд ногдох бүртгэлтэй интернет домайны тоо

Монгол Улсад төрийн байгууллагын «GOV.MN» домэйн нэр олгох үйлчилгээг “Үндэсний дата төв” УТҮГ хариуцдаг бол, «.mn» домэйн нэрийг олгох эрхийг «Датаком» ХХК, боловсролын байгууллагуудад зориулсан «edu.mn» домэйн нэрийг «Эрдэмнэт» сүлжээний төв тус тус хариуцан олгож байна.

Монгол улсад хичнээн домэйн нэр байдаг болон, түүнтэй холбоотой статистик мэдээлэл нь Үндэсний статистикийн хороо, ХХЗХ, Үндэсний дата төв, Датаком компанийн вэб хуудсанд нээлттэй хэлбэрээр байршаагүй байна. Энэ талаар ХХЗХ-ноос тодруулахад “mn” нэртэй домэйн нэр 16 мянга орчим бөгөөд үүний 50-60 хувь идэвхтэй ажилладаг талаар мэдэгдсэн бол Датаком компанийн хувьд мэдээлэл өгөх боломжгүй гэсэн хариултыг өгсөн юм. “Gov.mn” домэйн нэр Монгол улсад 1509 байдаг тухай Үндэсний дата төвөөс мэдээлэл өгсөн.

28. Тайлагнах хугацаанд хараат бус өрсөлдөөний комиссоос хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нэгдэл болон худалдан авалтыг шалгасан, шийдвэрлэсэн болон түдгэлзүүлсэн хувь хэмжээ

Монгол улсад хараат бус өрсөлдөөний комиссын үүрэг бүхий байгууллага нь Засгийн газрын тохируулагч агентлаг болох Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар болно. Тус байгууллага иргэдээс гомдол хүсэлт ирсэн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нэгдэл, худалдан авалтыг шалгах боломжтой байдаг. 2017-2018 онд үүнтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гаргаагүй байгаагаа албан бичгээр мэдэгдсэн.

ШӨХТГ-ын зүгээс 2018 оны есдүгээр сард “ТВ, радиогийн олон сувгийн хиймэл дагуулаар дамжуулах үйлчилгээний зах зээлд давамгайл байдалтай аж ахуй нэгжийг тодорхойлох судалгааг” хийжээ. Судалгааны дүнгээр “ДДэш ТВ” ХХК нь телевиз, радиогийн олон сувгийн хиймэл дагуулаар дамжуулах үйлчилгээний зах зээлд монополь аж ахуй нэгж байсан тул “давамгайл байдалтай аж ахуй нэгжээр” тогтоогдсон байна. Хэрэв давамгайл байдалтай хуулийн этгээд нь бусад аж ахуй нэгжтэй нэгдэн нийлсэн тохиолдолд хяналт шалгалт явуулж, судалгаа, шинжилгээ хийдэг аж. Өөрөөр хэлбэл, “ДДэш ТВ” ХХК нь өөр аж ахуйн нэгжтэй нийлбэл хяналт шалгалт хийх нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг, кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэхээс бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэл шинээр нээх, худалдаж авахад тусгайлсан ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлагагүй. Харин хуулийн дагуу

улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Тийнхүү бүртгүүлэх үйл явцад мэдээллийн хэрэгслийн эзэн, түүний зах зээлд эзлэх хувь, бизнесийн бусад төрөлд эзэмшиж буй хэмжээ зэрэг нь хамааралгүй бөгөөд гагцхүү хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүсгэн байгуулагчийн дүрэм, үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл, гүйцэтгэх удирдлага томилсон тухай тогтоол зэргийг шаарддаг.

Харин Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдэхдээ (Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагад тусгаснаар) "...тухайн зах зээлийн багтаамж, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгааны дүгнэлтэд үндэслэнэ..." хэмээсэн байдаг. Ийнхүү шийдвэрлэх үндэслэл нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хамааралтай байдаг ажээ.

29. Зохицуулах эрх бүхий газраас сонин, нийтлэл, интернет сайт эсвэл бусад төрлийн хэвлэл мэдээллийн нэвтрүүлгийг хаасан эсвэл цагдан хянасан хувь хэмжээ

Монгол улсад дээрх тохиолдлыг зохицуулах эрх бүхий байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах хороо болно. Харин Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар болон Цагдаагийн байгууллага өөрсдийн хамаарах хүрээнд дүгнэлт гаргах бөгөөд түүнд нь үндэслэн радио, телевиз, цахим сайтын хандалтыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалтуудыг Харилцаа холбооны зохицуулах хороо эрхэлдэг. Харин хэвлэмэл сонин, сэтгүүлийг хамардаггүй.

2017-2018 онд Оюуны өмчийн газар болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газраас телевиз, мэдээллийн сайтын үйл ажиллагааг зогсоосон, түдгэлзүүлсэн, түр хугацаагаар эрхийг хаасан арга хэмжээ аваагүй (дүгнэлт гаргаагүй) тухайгаа албан бичгээр мэдэгдсэн. Харин **Харилцаа холбооны зохицуулах хорооноос тус хугацаанд кабелийн сувгийн болон телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс 2 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээж, 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.** Түүнчлэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн, Садар самууныг сурталчилсан зэрэг үндэслэлээр Оюуны өмчийн улсын байцаагч, Цагдаагийн байгууллагын дүгнэлтээр нийт 134 сайтын Монгол улсаас хандах хандалтыг хязгаарласан байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 18-с үзнэ үү)

Дээрх байгууллагууд дор дурдсан 10 гаруй хууль, журамд үндэслэн телевиз, радио, мэдээллийн сайтын үйл ажиллагаанд хязгаарлалт тавьж байна.

Хуулиуд: "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль", "Хүүхэд хамгааллын тухай хууль", "Зар сурталчилгааны тухай хууль", "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль", "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль", "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль", "Сонгуулийн тухай хууль", "Соёлын тухай хууль"

Журам: "Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага",

“Тоон контентийн үйлчилгээнийн зохицуулалтын ерөнхий шаардлага”

Эдгээр хязгаарлалт нь нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготой боловч нэр томъёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүй юм. Мөн төрийн ямарваа нэгэн хэлбэрийн цензур хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавихыг хуулиар хориглосон ч (Хэвлэл Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйл) дээрх хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд төрийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэвлэл мэдээллийн зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалт Монгол Улсад хэвээр байна.

Мөн энэ хэсэгт Соёлын тухай хууль болон Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл заалтын талаар дурдахгүй өнгөрч болохгүй юм. Соёлын тухай хуульд 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ зохицуулалтын гол агуулга нь үндэсний нэвтрүүлгийг дэмжих төрийн бодлоготой уялдаж байгаа ч **хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт** юм.

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуульд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, түүний агуулгын хяналт, хэвлэмэл болон радио телевиз, цахим орчноор мэдээлэл түгээхтэй холбогдсон зохицуулалтыг оруулсан. **Тус хуульд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай ашиглан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараахыг хориглосон тухай зүйл заалт бий. Энэ заалтыг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ гэсэн.** Цахим хуудасны хандалтыг ижил зохицуулалтаар түдгэлзүүлэх заалт бий.

Гүтгэх, доромжлох асуудлыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх болсонтой холбогдуулан цагдаагийн ажилтан сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хориглох, саад болох тохиолдол илэрч байна. Тухайлбал, Монголын нэр нөлөө бүхий аж ахуй нэгжийн хууль бус зөрчлийн талаар нэвтрүүлэг бэлтгэх явцдаа, нэвтрүүлэг цацахаас өмнө хэсгийн цагдаатай сэтгүүлч уулзаж, бүтээлд нь гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл орсон эсэхийг лавлаж, зөвлөгөө авсан байна. Гэтэл цагдаа тухайн аж ахуй нэгжид сэтгүүлчийн бэлтгэж буй нэвтрүүлгийн талаар мэдээлсэн бөгөөд, тухайн байгууллагаас сэтгүүлчийг бүтээлээ цацахгүй байхыг сануулж, дарамт шахалт үзүүлсэн байна.

Мөн өөр нэг сэтгүүлч орон нутгийнхаа Засаг Даргын тамгын газар болон даргыг шүүмжилсний төлөө Зөрчлийн тухай хуулиар удаа дараа торгуулсан. Тухайн орон нутгийн цагдаагийн ажилтан дахин аймгийн Засаг дарга болон бусад зөрчилтэй асуудлаар нийтэлж, нэвтрүүлэхгүй байхыг ятгасан тохиолдол гарсан байна. Ятгах нь нэг төрлийн цагдан

хяналт юм.

30. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хүссэн мэдээлэлд Засгийн газрын зүгээс үр дүнтэй хариу үйлдэл хийсэн хувь хэмжээ

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хүссэн мэдээлэлд Засгийн газрын зүгээс үр дүнтэй хариу үйлдэл хийсэн хувь хэмжээг шууд тооцох боломжгүй байна. Гэхдээ ерөнхий нөхцөл байдлыг дараах судалгааны дүн зураглаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуулийн үнэлгээгээр жагсаахад Монгол улс 123 орноос 72-т жагссан байна. <https://www.rti-rating.org/country-data/>

Глоб интернэшнл төв 2019 онд Мэдээллийн Эрх Чөлөөний Өмгөөлөгчдийн Сүлжээ (FOIANet Network)-ээс бэлтгэсэн аргачлалын дагуу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн. Энэ судалгаанд санамсаргүй түүврийн аргаар төрийн найман байгууллагыг хамруулан 0-100 хүртэлх оноогоор үнэлж үзэхэд дунджаар 39.8 оноог авчээ.

Тус тайланд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хариуцдаг тусгай хороо Монгол Улсад байхгүй, төрийн байгууллагын мэдээллийн ажилтнууд мэдээлэл авах эрхийн хуулийн талаар хангалттай мэдлэггүй байгааг өгүүлсэн байна. Мөн байгууллагын нууц болон мэдээллийн нууцлалын тухай хэвшмэл ойлголттойгоос гадна дээрх чиглэлээр албан ёсны сургалтад хамрагдаагүй байгааг дурджээ.

31. Мэдээллийг нь хэвлэн нийтэлсний улмаас шийтгэл хүлээсэн, улс төр, компаний дарамтад орсон сэтгүүлч, хэвлэл мэдээллийн бусад ажилтны тоо

Глоб Интернэшнл төвөөс 2005 оноос хойш Монголын хэвлэл мэдээллийн салбар дахь мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийж, хэвлэлийн эрх чөлөө нийт тайланд тусгасаар ирсэн. 2017 онд нийт 91 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой мэргэжлийн эрхийн 182 зөрчил бүртгэгдсэн байна.

2017-2018 онд гарсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлөөс үзэхэд сүрдүүлсэн дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн гишүүнийг нь дарамталсан 20 тохиолдол, ажлын багаж хэрэгсэлд халдсан 7 тохиолдол, шүүх, хүчний байгууллагын дарамт, шүүхэд нэхэмжлэл гаргасан 108 тохиолдол, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан 11, нийтлэл нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт хэлбэрийн 7 тохиолдол байна. Сүүлийн нэг жилд ямар нэгэн байдлаар хуулиар шийтгэл хүлээсэн сэтгүүлч байхгүй байна.

Гэхдээ уг зөрчил нь Монголын сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхний эрхэд халдсан бүрэн тоо баримт биш бөгөөд энэ тухай дэлгэрүүлэн Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшинг тодорхойлох үндэсний хэмжээний судалгааны тайлангаас харах боломжтой юм.

32. Сэтгүүлч, хүний эрх хамгаалагч эсвэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэн хэн нэгэн алуулсан, алга болсон болон хоригдсон

тохиолдлын тоо. Ингэхдээ шүүхийн ажиллагаа эс ажиллагааны /НҮБ-ын тусгай горимд мэдэгдсэн гэх мэт/ хүрээнд төрийн хүлцэнгүй байдал, оролцоо, шийдвэртэйгээр эсвэл төрийн албан хаагч, төрийн захиргаанд хамаарах хэн нэгэн хүн тухайн хэргийг үйлдсэн тохиолдол.

Судалгааны явцад сэтгүүлч, хүний эрх хамгаалагч эсвэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэн хэн нэгэн алуулсан, алга болсон болон хоригдсон тохиолдол Монгол Улсад гараагүй болно.

33. Хүүхдүүдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгодог, "идэвхтэй сургалт"-д татагдан оролцсон сургуулийн хувь хэмжээ

2018 оны байдлаар Монгол улсад ерөнхий боловсролын 803 сургуульд 593,200 орчим хүүхэд суралцаж байна.¹⁵ Эдгээр сургуулиудын хичнээн нь сурагчдад "Идэвхтэй сургалт"-аар дамжуулан үзэл бодлоо чөлөөт илэрхийлэх боломж олгодог эсэх тухай статистик мэдээлэл байхгүй. Гэхдээ хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, оролцоог хангах зорилготой "Хүүхдийн оролцооны байгууллага" сургууль бүрт харилцан адилгүй тоогоор бий. Эдгээр нь клуб, дугуйлан, хүүхдийн өөрөө удирдах байгууллага гэх мэт ялгаатай нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

2017 онд Хүүхдийг ивээх сангаас "Өсвөр үеийнхний дуу хоолой" судалгааг хийжээ. Улаанбаатар хотын 11-16 насны хүүхдүүдийг хамруулан явуулсан тус судалгаанаас хүүхдийн оролцооны байгууллагын чанарын тухай дүр зургийг авч болохоор байна. Судалгаанд дурдсанаар:

- Оролцооны бүлэгт хамрагдсан хүүхдүүд хүүхдийн эрхийн талаар илүү мэдээлэлтэй байна.
- Дунд болон ахлах ангийн хүүхдүүд хүүхдийн оролцооны талаар илүү ойлголттой.
- Сургуулийн хоол, завсарлага, ангийн ажил гэх мэт сургуультай холбоотой үйл ажиллагааны талаар санал хүсэлтээ илэрхийлэх боломж **"заримдаа"** гардаг гэсэн байна.

Монгол улсын хувьд хүүхдийн оролцох эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг "Хүүхдийн эрхийн тухай конвенц", "Хүүхдийн тухай хууль", "Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр" зэргийн хүрээнд дэмжиж, үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн оролцооны байгууллагуудын сайн туршлага солилцох, үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор "Хүүхдийн оролцооны үндэсний зөвлөгөөн"-ийг 2018 оны 6-р сард Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан байна. Тус зөвлөгөөнд хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын 600 гаруй сурагчдын төлөөлөл оролцож, уриалга гаргажээ. Тус уриалгад хүүхдийн эрхийг хангаж, шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангах журам, хүүхдийн оролцоог дэмжих арга зүй, зураглалыг боловсруулж, хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулах, засаглалын бүх түвшинд хүүхэдтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад оролцох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хүүхдийн бодит

оролцоог дэмжих, сургууль бүрт хүүхдийн оролцооны танхим байгуулж, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, клуб, дугуйлангийн үйл ажиллагаа явуулах төсөв хуваарилах гэх мэт хүүхдийн оролцох эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг тусгажээ.

Түүнчлэн тус үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтод “Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх” тухай тусгасан. 2018-2019 онд үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан хэдий ч үүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл нээлттэй биш байна.

3.3 СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Хураангуй

- Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах нь хүний үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдолтой хэмээн сэтгүүлчид санал нэгтэй зөвшөөрч байна.
- Төрийн албан тушаалтан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын долоод нь тохиолдсон бөгөөд ийнхүү татгалзах гол шалтгаан нь нууцын тухай хууль ажээ.
- Түүнчлэн зарим төрийн байгууллагууд өөрсдийн дотоодын журмаар хүссэн мэдээллээ нууцын зэрэгт хамааруулж, олон нийтэд түгээхгүй байх арга хэмжээг авч, мэдээлэл авах эрхийг нь зөрчиж байна хэмээн сэтгүүлчид үзэж байна.
- Гурван сэтгүүлч тутмын хоёр нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт өртөж байсан бөгөөд хамгийн түгээмэл хэлбэр нь утсаар заналхийлэх, эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг айлгаж, дарамтлах зэргээр илэрч байна.
- Сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлол гэх мэт зүйлд 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид илүү өртөмтгий байгаа бол эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг болон гэр бүлийн гишүүдийг нь айлгаж, дарамтлах байдал эмэгтэй сэтгүүлчдэд илүү тохиолдож байна.
- Сэтгүүлчид бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болж утсаар дарамтанд өртөх нь энгийн, байдаг л асуудал мэт хэвшмэл ойлголт бий болсон, нөгөө талаас айлгаж сүрдүүлэх гэхээс өөр арга барилд шилжсэн буюу танил талаар дамжуулж яриулах, гуйх тохиолдол их байдаг хэмээсэн юм.
- Сэтгүүлчийн ажлын багаж хэрэгсэлд халдах явдал ойролцоогоор 5 сэтгүүлч тутмын гуравт нь тохиолдож байсан ч ажлын багаж хэрэгсэл

нь их хэмжээгээр гэмтээгүй, дахин ашиглах боломжтой хэвээр байгаа бол цагдаагийн байгууллагад гомдол гаргаад байдаггүй байна. Эмэгтэй сэтгүүлчдийн ажлын багаж хэрэгсэлд халдах байдал эрчүүдэд тохиолдох тохиолдлоос ялимгүй их байна.

- Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх төрлийн цензур 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Салбарын ажилчдын цалингийн хэмжээ бага, хэвлэл мэдээллийн байгууллага нь өөрөө томоохон бизнесийн бүлэглэл, улс төрчдийн эзэмшилд байгаа, түүнчлэн зарим сэтгүүлчдийн өөрийн үйлдэл нь энэ мэт зүйлсийг дэвэргэж буйг сэтгүүлчид хэлж байлаа.
- Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол судалгаанд хамрагдсан 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид хамгийн их тохиолдсон байна.
- Бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй нь холбогдуулан сэтгүүлчийг шүүх, цагдаагийн байгууллагаас дуудаж байсан тохиолдол 3 сэтгүүлч тутмын нэгд тулгарч байжээ.
- Эрх мэдэл бүхий албан тушаалтан, улс төрчийн нэр хүндэд халдсан, баримтын алдаа гаргасан, бодит байдлыг гэмт хэргийн шинжтэй бичсэн гэх зэрэг шалтгаанаар илүүтэй шүүх, цагдаагийн байгууллагад дуудагддаг хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь ямар нэг шийтгэл хүлээх, тэр дундаа торгууль хүлээхээс зайлсхийж, бэлтгэсэн мэдээллээ устгах зэргээр зөвшилцөх явдал цөөнгүй байдаг аж. Тэр бүү хэл редакцийн буруу тохиолдолд 20 сая төгрөгөөр торгуулахаас зайлсхийж, сэтгүүлчид хэргийг үүрүүлж, 2 сая төгрөгөөр торгуулах замыг сонгодог байна.
- Цахим шуудан, нийгмийн сүлжээний хаяг, түүнтэй холбоотой мэдээллээ алдах тохиолдол сэтгүүлчдэд гардаг ч интернет, мэдээллийн технологи, харилцаа холбооны компаниудаас цахим халдлагаас сэргийлсэн зөвлөгөө, сургалт, тусламж авах болжээ.
- Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 18 хувьд нь бие эрхтэн, эрүүл мэндэд нь халдсан тохиолдол гарч байжээ. Энэ нь ихэнх тохиолдолд оройн цагаар хоолонд урих, хувийн чат үлдээх, утсаар ярих, болзоонд урих, секс санал тавих зэргээр бэлгийн дарамтын шинжтэй үйлдлээр илэрч байсан байна.
- Ямар нэг хэлбэрээр эрх нь зөрчигдсөн сэтгүүлчид тэр тухайгаа олон нийт болон мэргэжлийн байгууллагад хандахаас илүүтэй редакция мэдэгдэж байжээ.
- Тухайн зөрчлийг ноцтой биш, их хэмжээний хохирол амсаагүй гэж үзсэн үед зохих байгууллагуудад мэдэгддэггүй байна. Нэг талаас үүнийг цагаа үрсэн явдал гэж үздэг, нөгөө талаас сэтгүүлчид өөрсдөө хууль, эрх зүйн мэдлэг муу, ямар нэг байдлаар шүүх цагдаагийн байгууллагад

дуудагдахдаа өмгөөлөгч, нийгмийн байгууллагаас зөвлөгөө авах тал дээр дутмаг байдагтай холбоотой.

- Сэтгүүлчид эрсдэлтэй томилолтоос татгалзах эрхтэй гэж дийлэнх нь үзэж байгаа ч, зарим тохиолдолд дээд албан тушаалтны даалгавар бол эрсдэлтэй байсан ч явах ёстой, мөн сэтгүүлчийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буй хэрэг гэж үзэж байна.
- Ажил олгогч, сэтгүүлийн хооронд хийгдсэн хөдөлмөрийн гэрээнд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах тухай дийлэнх тохиолдолд огт тусгагддаггүй байна. Түүнчлэн ажилтнуудад зориулсан аюулгүй байдлын баримт бичиг ч байхгүй байна.
- Ажилтан (сэтгүүлч) тэр бүр даатгалд хамрагдаад байдаггүй бөгөөд даатгал төлөхөөс илүүтэй даатгалд зарцуулах зардлыг цалин, урамшуулал хэлбэрээр авахыг тэргүүнд тавьдаг байна.

Дэлгэрэнгүй үр дүн

Хэвлэлийн эрх чөлөө гэхээр бүгд л сэтгүүлчдийн эрхийг хангах, сэтгүүлчдэд илүү ач холбогдол өгөх юм шиг ойлгоод байдаг. Яг үнэндээ энэ нь хүний язгуур эрх болсон мэдэх эрх дээр тулгуурласан эрх чөлөө юм.

37 настай, эрэгтэй

- Судалгаанаас харахад **“хүн бүр үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхтэй, хэвлэлийн эрх чөлөө бол ард түмний эрх чөлөө юм”** хэмээн сэтгүүлчид санал нэгтгэйгээр зөвшөөрч байна. Улмаар сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах нь хүний үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдолтой гэдэг дээр ч санал нэгтэй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 19-с үзнэ үү)

Гэхдээ сэтгүүлчийн аюулгүй байдал гэдгийг зөвхөн тухайн сэтгүүлчид халдах, хүч хэрэглэх, түрэмгийлэх гэдгээр ойлгож байгаа тохиолдол мөн гарч байлаа.

Хүмүүс дарамталж ярихаасаа илүү “Одоо тэр мэдээгээ устгаад өгөөч” гэж гуйдаг болсон. Гэхдээ гуйх нь хэвлэлийн эрх чөлөөнд халдаж байгаа дарамт гэж Глоб Интернэшнл төвийн Наранжаргал тайлбарлаж байсан. Бид энэ мэтчилэн тохиолдлуудыг амьдрал дээр байдаг л асуудал мэтээр ойлгоод, сэтгүүлчийн аюулгүй байдалд нөлөөлөөд байгаа гэдгийг ялгаж харахгүй тохиолдол их байна.

35 настай, эмэгтэй

- ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлд заасан “Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх”-ийн хэрэгжилт Монгол улсад ямар түвшинд

байгаа талаарх сэтгүүлчдийн санал бодлыг тодруулахад **5 сэтгүүлч тутмын нэг нь** сайн буюу маш сайн гэж үнэлжээ. Харин бусад нь энэ эрх хангалттай хэрэгжиж чадахгүй байна хэмээн үзэж байна.

- Судалгаанаас харахад 2 сэтгүүлч тутмын нэг нь **"хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн эсрэг заналхийлэл байдаг, гэсэн хэдий ч сэтгүүлчийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг шийтгэлгүй өнгөрдөг"** гэж үзжээ.
- Сэтгүүлчийн аюулгүй байдал зөрчигдсөн тухай бүрт мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрлэх арга хэмжээ авдаггүй гэж судалгаанд оролцогчид хэлж байлаа

СЭТГҮҮЛЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Мэдээлэл өгөхөөс татгалзсан, мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн тохиолдол

Төрийн албан тушаалтан "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль"-ийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын долоод нь дор хаяж нэг удаа тохиолдож байжээ. Нэг сэтгүүлчид дунджаар 4-6 удаа ийм хүндрэл тохиолдож байсан байна.

Төрийн албан тушаалтан тус хуулийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж буй шалтгаан нь "Төрийн болон албаны нууцын тухай хууль"-ийн 14.1-т заасан "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрлээр батална" гэж заасан хуулийн зүйл заалт болохыг сэтгүүлчид хэлж байлаа.

Улсын нууцын хууль хэдий байвч сүүлийн үед мэдээллийг хаадаг арга гараад ирсэн нь Байгууллагын дотоод журам гэх зүйл. Тэр журмаас хамаарч байгууллага өөрөө дотроо хуулиас давсан цензур тогтоочихдог.

57 настай, эрэгтэй

Хэвлэлийн төлөөлөгч нь мэдээлэл өгөх биш хаах хүмүүс болчихдог. Нууцын тухай хуулиа ялгаж, салгаж ойлгож мэдэхгүй. Жишээлбэл, Санхүүгийн зохицуулах хороо гэхэд удирдлагаас гаргаж байгаа баримт бичиг бүр нууц байна аа гээд оруулчихсан ч байх шиг. Хуультайгаа нийцэхгүй ийм журмууд бас гаргачихсан л байдаг.

32 настай, эмэгтэй

Санхүүгийн зохицуулах хорооны албаны нууцад хамаарах

мэдээллийн жагсаалтад “Хорооны даргаас дотоод мэдээлэл гэж тогтоосон бүх төрлийн мэдээ, мэдээлэл” гэж байгаа нь тухайн албан тушаалтны хувийн цензур нөлөөлж байгааг харж болохоор байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 20-с үзнэ үү)

Нөгөөтээгүүр нууцад хамаарахгүй мэдээллийг олон шат дамжлагаар дамжуулж цаг алдах, эсвэл албан ёсны цахим сайтаас мэдээллээ авахыг санал болгох зэргээр хүндрэл учруулж, хэвлэлийн төлөөлөгч нь бодитой мэдээлэл өгөхөөс зайлсхийж, зөвхөн эерэг мэдээлэл өгч, тухайн байгууллагаа хамгаалах үүрэгтэйгээр хэвлэл мэдээллийн ажилтнуудтай харилцдаг болохыг судалгаанд оролцогчид хэлж байлаа.

2. Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан гэх мэт тохиолдол

Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн гуравны хоёр нь (67 хувь) нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт өртөж байжээ. Дээрх үйлдлүүд нэг сэтгүүлчид дунджаар 3-4 удаа тохиолдсоныг сэтгүүлчид хэлж байлаа.

Сэтгүүлчдэд тохиолдож байсан хүндрэлүүдийг ангилж харвал утсаар заналхийлэх, редакцийн хамт олныг дарамтлах тэргүүтэй дараах үйлдлүүдийг нэрлэсэн байна.

График 2. Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон тохиолдлууд



Бичсэн нийтлэл нэвтрүүлэг, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болж сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлол гэх мэт зүйлд 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид илүү өртөмтгий байгаа нь судалгааны явцад мэдэгдсэн.

Харин эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг айлгаж, дарамтлах, ажил хэргийн шалтгаанаар утсаар тагнаж, чагнах, гэр бүлийн гишүүдийг нь айлгаж, дарамтлах байдал эмэгтэй сэтгүүлчдэд илүү тохиолдож байсан бол эрэгтэй сэтгүүлчдийг хүчний байгууллагаас эсвэл өөр эрх мэдэлтэй, хүч илүү хүмүүсээр айлгаж дарамтлах байдал илүүтэй байжээ.

НИТХ-ын төлөөлөгч “А”-ийн төрсөн дүү “Б” олон нийтийн газар сэлэм эргүүлэн танхайрсан хэргийн тухай хамгийн анх манайх гаргаж тавихад захирал, редактор, сэтгүүлч, редакцийн бас ажилтны гээд 4 хүний утас өдөржингөө дуугарсан. Бид нар утсаараа ч ярьж чадахгүй, фэйсбүүк рүүгээ орж чадахгүй, олон хүн наад мэдээгээ авчихаач гээд байж байтал нөгөө “А” нь дүүтэйгээ орж ирээд “Наадхаа авчих” гэж сүрдүүлсэн. Манайх ч харьяа байгууллагынхаа хамгаалалтын албыг аваад би бас хэд хоног хамгаалалттай байсан. Тэгээд сүүлдээ манай толгой компаниар дамжуулж авахуулсан. Энэ мэтчилэнгээр редакцруу орж ирдэг юмнууд бол зөндөө байгаа

33 настай, эмэгтэй

Фокус бүлгийн ярилцлагын үеэр сэтгүүлчид бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болж утсаар дарамтанд өртөх нь энгийн, байдаг л асуудал мэт хэвшмэл ойлголт бий болсон, нөгөө талаас айлгаж сүрдүүлэх гэхээс өөр арга барилд шилжсэн буюу танил талаар дамжуулж яриулах, гуйх тохиолдол их байдаг хэмээсэн юм.

Хүмүүс дарамталж ярихаасаа илүү тэр мэдээгээ устгаад өгөөч гэж гуйдаг болсон. Гэхдээ тэр гуйх чинь ч гэсэн өөрөө хэвлэлийн эрх чөлөөнд халдаж байгаа дарамт гэж мэргэжилтнүүд хэлж байсан.

35 настай, эмэгтэй

3. Ажлын багаж хэрэгсэлд халдсан тохиолдол

Сэтгүүлчийн ажлын багаж хэрэгсэлд халдах явдал ойролцоогоор 5 сэтгүүлч тутмын гуравт нь (58 хувь) тохиолдож байсан бөгөөд залуу сэтгүүлчид илүүтэй өртөж байна.

Хүснэгт 5. Ажлын багаж хэрэгсэлд халдсан тоо_насаар

Нас	25-хүртэлх нас	26-30 нас	31-35 нас	36-40 нас	41-45 нас	46-50 нас	51-ээс дээш
Тохиолдлын тоо	5	4	4	3	1	3	1

Эмэгтэй сэтгүүлчдийн ажлын багаж хэрэгсэлд халдах байдал эрчүүдэд тохиолдох тохиолдлоос ялимгүй их буюу 4:3 харьцаатай байна.

Сэтгүүлч, зураглаачийн зүгээс ажлын багаж хэрэгсэл нь их хэмжээгээр гэмтээгүй, дахин ашиглах боломжтой хэвээр байгаа бол цагдаагийн байгууллагад гомдол гаргаад байдаггүй. Тэдэнд хандлаа ч үр дүнгүй гэж үзэж байна.


УБТЗ шалгалт авах нэрийдлээр 50 гаруй насны эмэгтэйчүүдийг ажлаас нь халж буй тухай мэдээллийн мөрөөр тодруулга хийх гэж ороход тэндхийн хуулийн ахлах мэргэжилтэн нь манай зураглаачийг зодож, камерийг нь шууд булаасан. 2, 3 хүн нийлээд цохиод авч байх жишээний. Гэтэл прокурор үүнийг хэрэгсэхгүй болгож, хэргийг

манай зураглаачийн буруу байсан гэж үзсэн.

33 настай, эмэгтэй

Эрүүл мэнд, техник гэхээсээ илүү мемори картыг нь авч яваад доторхыг нь устгаад буцаагаад өгчихдөг. Ингээд баримт нь байхгүй болохоор тэр хүн тэрийг үнэлэх боломжгүй, гомдол гаргаад явъя гэхээр хэн ч тоодоггүй, анхаардаггүй. Ийм юмнууд зөндөө гардаг. Тэгээд одоо нэгэнтээ өнгөрчихсөн энийгээ орхиё гээд л ингээд л цаашаа явдаг. Гомдол гэхэд хэцүү, биш гэхэд хэцүү.

37 настай, эрэгтэй




АНУ-ын иргэн, зэвсэгт хүчний хошууч М.Стюарт Улаанбаатар дахь Шангри-Ла зочид буудлын өрөөнд өөрийгөө боомилсон байдалтай нас барсан талаарх мэдээллийг сурвалжлахаар очсон "Засгийн газрын мэдээ" сонины сэтгүүлч Э.Батцэцэг, фото сэтгүүлч С.Батсайхан нарыг зураг авлаа гэсэн үндэслэлээр биед нь нэгжлэг хийж, утсан дээрх зургийг устгасан, зурагчны гэрэл зургийн аппаратыг хураан авч, баривчилсан.

4. Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур

Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх төрлийн цензур 2 сэтгүүлч тутмын нэгд (52 хувь) тохиолдож байжээ.

Нийтлэл нэвтрүүлгийг нийтлэгдэх, нэвтрүүлэхээс өмнө хориглож байсан тохиолдол ойролцоогоор 5 сэтгүүлч тутмын гуравт, бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэхийг хориглохын тулд мөнгө, бэлэг сэлт, бусад эд зүйлс өгөхөөр амалж байсан тохиолдол ойролцоогоор 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ.

График 3. Цензурын хэлбэр



Сэтгүүлчид ийнхүү хориг, цензурт өртөж буй шалтгааныг хэд хэдэн хүчин зүйлээр тайлбарлаж байгаагийн нэг нь хэвлэл мэдээллийн салбарын ажилчдын цалингийн хэмжээ бага байгаатай холбон тайлбарлаж байв. Түүнчлэн зарим

сэтгүүлчдийн өөрийн үйлдэл нь энэ мэт зүйлсийг дэвэргэж буйг өгүүлж байлаа.

Эгчийнх нь, ахынх нь таньдаг хүн, би тэр хүнээс байр авчихсан юм, чи энийгээ устгаад өгөөч, мөнгө өгье, гэрээ хийлгэж өгье гэж сэтгүүлчид өөрсдөө яриад, гар хөл нь болоод байгаа нь улс төрчдөөс илүү хамгийн том аюул занал гэж би бодож байна.

35 настай, эмэгтэй

Дараагийн нэг шалтгаан нь хэвлэл мэдээллийн байгууллага нь өөрөө томоохон бизнесийн бүлэглэл, улс төрчдийн эзэмшилд байгаа нь редакцийн хараат бус байдлыг бий болгож, сэтгүүлчийн бэлдэхийг хүссэн нийтлэл, нэвтрүүлгийг дэмжихгүй байх, хориглох үндэс суурь нь болж байна гэж үзэж байна.

Зөвхөн улс төр гэлтгүй, бизнесийн том бүлэглэлүүдийн ашиг сонирхол бас их хамаарч, хэвлэл мэдээллийн байгууллагууд эзний хамааралд орчихоод байна. Анхнаасаа өөрсдийнхөө нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага байгуулж байгаа нь редакцийн хараат бус байдлыг бий болгож байна.

35 настай, эмэгтэй

Эцэст нь сэтгүүлчдийн, салбарын нэр хүнд унасан байгаа нь хэн хүссэн нь мөнгө өгөөд сэтгүүлчдийн амыг барьж болно гэдэг ойлголтыг бий болгож ийм оролдлогууд хийх нөхцлийг бүрдүүлж байна. Мөн сэтгүүлчид мөнгө авч нийтлэл нэвтрүүлэг бэлтгэдэг, эсвэл бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгээ түгээхээ больдог, шантаажилдаг гэх зэрэг ойлголтыг олон нийтэд төрүүлж, салбарын нэр хүндийг унагах, сэтгүүлчдэд итгэх итгэлийг бууруулж байна.

5. Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол

Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 51% буюу 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид хамгийн их тохиолдсон байна. Сэтгүүлчийн нас ахихын хэрээр дээрх тохиолдол буурч байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 6. Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол_насаар

Нас	25 хүртэлх нас	26-30 нас	31-35 нас	36-40 нас	41-45 нас	46-50 нас	51-ээс дээш
Тохиолдлын тоо	6	4	5	4	2	2	4

Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдолд сэтгүүлчийн хүйсийн ялгаа хамааралгүй байна. Дунджаар нэг сэтгүүлч 4 удаа дээрх нөхцөл байдалд орж байжээ.

Сэтгүүлчийн бичсэн мэдээ, нийтлэл гарсны дараа нэр дурдагдсан байгууллага болон эрх мэдэл бүхий албан тушаалтан ямар эх сурвалжаас мэдээлэл авсан тухай асуудаг. Мөн сэтгүүлчийн эсрэг шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхээс сэтгүүлчийг тухайн мэдээллийн баримтаа нотлохыг шаарддаг нь нууц эх сурвалжаа илчлэхээс өөр аргагүй байдалд оруулж байна.

Ямар ч мэдээлэл гарсан тэгээд л шууд холбоотой хүн нь хэний захиалгаар бичсэн, хэнээс мөнгө авсан гэж асууж байна шүү дээ...

55 настай, эмэгтэй

6. Шүүх, хүчний байгууллагын дарамт, шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдол

Судалгаанд оролцогчдоос “Таны бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй холбогдуулан шүүх, цагдаагийн байгууллагаас дуудаж байсан уу? гэж асуухад судалгаанд оролцогчдын 36 хувь буюу 3 сэтгүүлч тутмын нэг нь тийм гэж хариулсан.

Тодруулбал эрх мэдэл бүхий албан тушаалтан, улс төрчийн нэр хүндэд халдсан, баримтын алдаа гаргасан, бодит байдлыг гэмт хэргийн шинжтэй бичсэн гэх зэрэг шалтгаанаар илүүтэй шүүх, цагдаагийн байгууллагад дуудагдаж ажээ.

Ийнхүү олон удаа шүүхэд дуудагдах үндэслэл нь “Зөрчлийн хууль” гэж сэтгүүлчид үзсэн. Мөн судалгаанд оролцогчид “Зөрчлийн хууль”-ийг улс төрчдийн өөрсдийгөө хамгаалахын тулд баталсан хууль гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллага улс төрчдийн хүсэл зоригийг, гомдлыг дарах зорилготой байгууллага болчихоод байгаа юм шиг санагддаг. Одоо чинь тэгээд зөрчлийн хуулиар сэтгүүлчээ торгуулсан нь ашигтай болчихоод байна шүү дээ.

32 настай, эмэгтэй

Манай редакцийн хувьд улс төрчдийн хэлсэн үгийг бичээд л дуудагдаад байгаа. Өөрсдөө чуулганы танхимд хэлчихээд л, тэрийг нь бичихээр доромжиллоо гээд гомдол гаргаж байна.

55 настай, эмэгтэй

Шүүх, цагдаагийн газар дуудагдсан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь ямар нэг шийтгэл хүлээх, тэр дундаа торгууль хүлээхээс зайлсхийж, бэлтгэсэн мэдээллээ устгах зэргээр зөвшилцөх явдал цөөнгүй байдаг аж. Ямар нэг байдлаар хэвлэл мэдээллийн байгууллага буюу редакцийн буруу тохиолдолд 20 сая төгрөгөөр торгуулахаас зайлсхийж, сэтгүүлчид хэргийг үүрүүлж, 2 сая төгрөгөөр торгуулах замыг сонгодог байна.

Зөрчлийн хуулиар редакц нь өөрөө хариуцлага хүлээж 20 саяар торгуулахгүйн тулд сэтгүүлчээ 2 сая төгрөгөөр торгуулаад гэм бурууг нь өөр дээрээ үүрчихээч гэх байдлаар шийдвэрлэх нөхцөл бүрдэж байна.

32 настай, эмэгтэй

7. Хувийн цахим хаяг, түүнтэй холбоотой мэдээллүүдээ алдаж байсан тохиолдол

Хувийн цахим хаяг (цахим шуудан & нийгмийн сүлжээний хаягууд), түүнтэй холбоотой мэдээллүүдээ алдаж байсан гэж судалгаанд оролцогчдын 20 хувь буюу 5 сэтгүүлч тутмын нэг нь хариулсан. Хүйсийн хувьд ангилж харвал эмэгтэй

сэтгүүлчид эрэгтэй сэтгүүлчдээс илүү хувийн цахим хаяг болон түүнтэй холбоотой мэдээллүүдээ алдаж байжээ.

Тус сэтгүүлчдээс цахим халдлагад өртөхгүйн тулд ямар нэг програм хангамж болон цахим гэмт хэргээс сэргийлэх хамгаалалт хэрэглэж байсан эсэхийг тодруулахад 57 хувь тийм гэж хариулсан. Харин үлдсэн 43 хувь өмнөх хэв маягаараа ажиллаж байгаа болно.

Харин 3 сэтгүүлч тутмын нэг нь интернет, мэдээллийн технологи, харилцаа холбооны компаниудаас цахим халдлагаас сэргийлсэн зөвлөгөө, сургалт, тусламж авч байсан гэжээ.

Сүүлд ТЕГ-аас сургалт хийж байсан. Мэргэжлийн байгууллагуудаас нь сургалт авах боломжтой юм шиг байгаа юм. Ер нь холбоо сүлбээтэй нь ч юм уу эсвэл, илүү хөдөлгөөнтэй нэг нь “за чиний утсыг чагнаж байгаа нь ингэж мэдэгддэг юм шүү, 14 хоногтоо нэг фэйсбүүкийнхээ кодыг солиод байгаарай” ч гэдэг юмуу мэдээлэл аваад байх шиг байдаг.

33 настай, эмэгтэй

Гэхдээ интернет орчин дахь болон мэдээллийн технологийн чиглэлийн мэдлэг дутмаг байгаа нь тухайн нөхцөл байдалд орсон эсэхээ тодорхойлж чадахгүй байдалд хүргэж байна.

Мэдээллийн сайт халдлагад өртөж ажиллахгүй болсон тохиолдол бий.


2015 оны 12 сарын 7-нд Хууль зүйн сайд асан Х.Тэмүжинг сайт дээрээ гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг гээд 2 бичлэг гаргасан. Ерөөсөө 2 дахь нь гараад л тэр өдөр нь үдээс хойш манай сайт хакердуулсан. Бид зохих түвшинд нь, байж болох хэмжээнд нь явсан. Их хурал дээр хүртэл гомдол гаргасан ч хэн ч барагдуулаагүй. Бидэнд 2 IP хаяг илрүүлсэн, нэгнийх нь ард 3000 хэрэглэгч, нөгөөхийнх нь ард 4000 хэрэглэгч байна гэсэн хариу өгсөн. Сүүлд албан бус шугамаар сонсоход 2 залууг тогтоосон юм байналээ. Гэхдээ энэ тухай бидэнд хэлээгүй. Түүнээс зөв зүгээр байж байгаад, зүгээр сууж байгаад за за энэ сайтыг хакердчихъя гээд хакердахгүй шүү дээ. Ямар нэг зорилготой л хийгдсэн ажил гэж боддог.

55 настай, эмэгтэй

8. Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан тохиолдол

Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан хэлбэрт ямар нэг байдлаар бэлгийн дарамт учруулсан эсэх, бие эрхтэнд нь халдсан байдлыг оруулсан. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 18 хувь нь дээрх нөхцөлд орж байсан гэжээ. Эдгээр үйлдлүүдийг доорх байдлаар ангилбал:

График 4. Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан тохиолдол_төрлөөр



Эх сурвалж оройн цагаар хоолонд урих, хувийн чат үлдээх, утсаар ярих, болзоонд урих, секс санал тавих зэргээр бэлгийн дарамтын шинжтэй үйлдэл гаргаж байсан гэж 5 сэтгүүлч тутмын нэг хариулсан. Ийнхүү дарамтад өртөж байсан сэтгүүлч дунджаар 4 удаа тухайн байдалд орж байсан байна.

Мөн 5 сэтгүүлч тутмын нэгийг түлхэх, цохих гэх зэргээр хөнгөн болон хүнд гэмтэл учруулж байсан ба нэг сэтгүүлч дунджаар 3 удаа ажил үүргээ гүйцэтгэж яваад дээрх нөхцөлд орж байжээ.

Бие эрхтэнд халдах, ажлын байрны бэлгийн дарамт 25 хүртэлх насны залуу сэтгүүлчдэд илүүтэй тохиолдсон байна. Харин бие эрхтэнд ямар нэг байдлаар халдаж байсан тохиолдол эмэгтэй сэтгүүлчдэд эрэгтэйчүүдээс 2 дахин их буюу 4 удаагийн давтамжтай тохиолджээ.

Ажил үүргээ гүйцэтгэж явсан сэтгүүлчийн биед хуулийн ажилтан халдаж, санаантайгаар зодож танхайрсан асуудлаар "Ийгл ньос" телевиз цагдаагийн байгууллагад хандсан нь сэтгүүлчийнхээ өмнөөс редакци нь дуугарсан анхны тохиолдол болж байна.

Сэтгүүлчид халдсан асуудлаар "Ийгл ньос" телевиз Цагдаагийн байгууллагад хандлаа



© Бүлээн / © 2019-07-30 20:03:00 / © 42




СЭТГҮҮЛЧИЙН БИЕД ХАЛДСАН АЖИЛТАНД ХЭДХЯ ХАРИУЦЛАГА ТООЦ

- Өнгөрсөн баасан гаригт Монгол, Туркийн хамтарсан сургуулийн дэд захирал Вэйсел Акчайг хулгайлсан гэх үйлдэл гарсан. Тухайн үйл явдлыг газар дээрээс нь сурвалжилж, ажлаа хийснийх нь төлөө "Ийгл ньос" телевизийн сэтгүүлч Б.Батцэцэгийн биед хуулийн ажилтан халдаж, санаатайгаар зодож танхайрсан үйлдэл гаргажээ. Мэдээллийг газар дээрээс нь шуурхай сурвалжлан, олон нийтэд хүргэх албан үүргээ гүйцэтгэж байхад нь сэтгүүлчийн биед халдсан хэрэгт харамсал илэрхийлж, Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-нд шаардлага хүргүүлж байна. Шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд МСНЗ нь Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд заасан мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, дараагийн шат шатны арга хэмжээ авч ажиллах болно. Улмаар сэтгүүлчийн мэргэжлийн эрх ашгийг хамгаалах, жагсаал цуглаан зохион байгуулах арга хэмжээ авахаа мэдэгдэж байна. Сэтгүүлч Б.Батцэцэгийн биед халдсан хуулийн ажилтны мэдээллийг ХЗДХЯ-наас гаргуулж авах, тухайн ажилтанд хуулийн дагуу хариуцлага тооцох шаардлага хүргүүлж байна.

Сэтгүүлчийн аюулгүй байдал зөрчигдөхөд авсан арга хэмжээ

Эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдийн 23 хувь нь өөрийн редакцдаа мэдэгдсэн байна. Харин олон нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болон ИНБ-д хандах, цагдаа шүүхийн байгууллагад хандсан тохиолдол цөөн байна. Ихэнх тохиолдолд тухайн зөрчлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хөөн хэлэлцдэггүй болох нь харагдаж байна.

График 5. Сэтгүүлч аюулгүй байдал нь зөрчигдсөн тохиолдолд хэнд ханддаг вэ?



Тухайн зөрчлийг ноцтой биш, ямар нэг байдлаар их хэмжээний хохирол амсаагүй гэж үзсэн үед зохих байгууллагуудад мэдэгддэггүй байна. Учир нь сэтгүүлчдийн хувьд тухайн асуудлаа аар саархан асуудал мэтээр үзэж, хөөцөлдөж явах нь цагаа үрсэн явдал гэж үздэг түгээмэл ойлголтоос улбаатай ажээ.

Ноцтой биш бол хэн ч араас нь явахгүй шүү дээ. Яагаад гэвэл наад чинь цаг зав, хөдөлмөр хэрэгтэй ажил. Тэрийг хөөцөлдөөд явах завтай хүн редакцид байхгүй. Эрүүл мэндийн хувьд ноцтой гэмтэл авчихаагүй, техник тоног төхөөрөмж нь бүр хэрэглэх аргагүй болтлоо эвдрээгүй бол тэгээд л өөрсдөө аргалаад л өнгөрдөг

55 настай, эмэгтэй

Цагдаа дээр нэг очиж өргөдлөө өгөөд, утсаар хэд ярина. Тэгээд л хаядаг. Цагдаа нь эзэн нь олдсонгүй гээд л хаячихдаг.

40 настай, эмэгтэй

Хүндрэлтэй асуудал тулгарвал редакц дотроо хамгаалалт авах уу яах уу гээд л. Редакц шаардлагатай тохиолдолд хамгаалагч гаргаж өгнө. Гаргаж өгөхгүй бол тэр чигээрээ л байна.

33 настай, эмэгтэй

Нөгөө талаас сэтгүүлчид өөрсдөө хууль, эрх зүйн мэдлэг муу, ямар нэг байдлаар шүүх цагдаагийн байгууллагад дуудагдахдаа өмгөөлөгч, нийгмийн байгууллагаас зөвлөгөө авах тал дээр дутмаг байна.

Сэтгүүлчид бидэнд эрх зүйн мэдлэг мэдээлэл бол зайлшгүй шаардлагатай.

Мэдлэггүйгээсээ болж хаана, хэзээ миний эрх зөрчигдөөд байгаа талаар ойлгодоггүй, ойлгосон ч холбогдох газар нь мэдэгдэж, шийдвэрлүүлдэггүй тал бий.

32 настай, эмэгтэй

Монголд байгаа хамгийн гайгүй, бодитой хамгаалалт үзүүлж чадах газар бол Глоб Интернэшнл төв л байгаа. Хэвлэлийн зөвлөл бол ёс зүйн болон мэргэжлийн асуудалтай холбоотой. Глоб Интернэшнл төв редакц болоод сэтгүүлчид аюул заналхийх, хэвлэлийн эрх чөлөөнд нь халдсан тохиолдолд зөвлөмжүүд өгч чаддаг. Тэндэхийн хуульчаас нь шаардлагатай бол зөвлөгөө авч болно.

Гэхдээ манай редакцийн хувьд тусдаа өмгөөллийн компанитай гэрээ байгуулаад хамтарч ажиллаж байгаа. Шүүх цагдаагийн асуудал дээр.

35 настай, эмэгтэй

Хуулийн зөвлөхтэй хэвлэл цөөхөн. Сэтгүүлч нь асуудалд орлоо гэхэд аль болох үнэгүй өмгөөлөгч хайдаг. Үнэгүй юм гэдэг чинь цаанаасаа сэтгэл гаргахгүй байдаг юм байна лээ. Ер нь редакц болгон л нэг хуулийн чиглэлийн мэдээллийг сэтгүүлчдэдээ өгч байвал гэж боддог.

32 настай, эмэгтэй

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангахад оролцож буй оролцоо

- Сэтгүүлчийн хувьд Та эрсдэлтэй томилолтоос татгалзах эрх бий юу? гэж асуухад судалгаанд оролцогсдын 56 хувь нь тийм, 24 хувь нь үгүй, 20 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан. Сэтгүүлчид эрсдэлтэй томилолтоос татгалзах эрхтэй гэж дийлэнх нь хариулж байсан ч, зарим тохиолдолд редакц, албаны дарга гэх мэтчилэн дээд албан тушаалтны даалгавар бол эрсдэлтэй байсан ч явах ёстой гэж ойлгож байна. Мөн эрсдэлтэй томилолтод явах нь сэтгүүлчийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буй хэрэг гэж үзэж байна. Доорх кэйсээс харвал бие давхар эмэгтэйг эрсдэлтэй томилолтод явуулж буй нь редакцийн хувьд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тал дээр анхаарахгүй байгааг харуулж байна.

2016 онд Америкийн иргэн Централ Тоуэр дээр тэсрэх бөмбөг тавьсан тухай мэдээ бэлтгэх болж манай редактор нэг сэтгүүлчийг зураглаачтай яв гэсэн. Гэтэл тухайн сэтгүүлч “Би тийшээ явж чадахгүй ээ. Тэр чинь дэлбэрээд би үхчихвэл яах юм” гээд яваагүй. Тэгсэн чинь албаны дарга “Тэгвэл чи яв” гээд надад хэлсэн. Тухайн үейд би төрөх гээд 7 орчим сартай, нэлээд том гэдэстэй байсан. Тэгээд явж байсан. Хэдий эрсдэлтэй томилолт ч гэлээ тэр үед би татгалзаад байх эрх байгаа ч гэсэн олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг байгаа учраас би явахгүй гээд татгалзах нь бас хаашаа ч юм гэж бодоод явж байсан.

30 настай, эмэгтэй

- Хэвлэл мэдээллийн байгууллага нь сэтгүүлчээ эрсдэлтэй томилолтод илгээхдээ өмнө нь орчин, эрсдлийн талаарх мэдээлэл урьдчилан өгдөг эсэхийг тодруулахад 43% нь тийм гэж хариулсан бол 39 хувь нь үгүй, 18 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан.
- Хөдөлмөрийн гэрээндээ ажил олгогч оновчтой нөхцөлийг тусгасан байдаг уу? гэж асуухад сэтгүүлчдийн 39 хувь нь тийм, 33 хувь нь үгүй, 28 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан.

Ажил олгогч болон сэтгүүлчийн хөдөлмөрийн гэрээнд тэдний аюулгүй байдлыг хамгаалах ямар заалт хэрхэн ордог талаар доорх баримтаар харууллаа.

Гэрээнд Гурав. Ажилтны эрх, үүрэг гэсэн хэсэгт **“Ажилтан нь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, техникийн болон галын аюулгүй байдлын дүрэм зааврыг чанд мөрдөж ажиллана”** гэж орсон байгаа нь ерөнхий байдлаар ойлгогдож байна. Гэхдээ тухайн сэтгүүлчийн аюулгүй байдал зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээ гэх мэтчилэн нарийн тусгагдаагүй болно.

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ
2014 оны 07 дугаар сарын 11-ний өдөр № 06/15 Улаанбаатар хот
Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Хөдөлмөрийн гэрээ "гэрээ" гэхэд Хөдөлмөрийн тухай хууль, телевизийн Дотоод журмыг удирдлага болгон нэг талаас "ТЭВ" телевизийг төлөөлөн Гүйцэтгэх захирал /.../ сар /.../д "Ажил олгогч" гэх, нөгөө талаас /.../ тоот /.../ дугаартай /.../ -ийн /.../ цашид /.../ гэх/ нэр хэрэглэн тохиролцож дараах нөхцлөөр байгуулаа.

1.2. Ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулах, талуудын нийтлэг эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.1. Энэхүү гэрээг 2014 оны /.../ оны /.../ дүгээр сарын /.../ өдрөөс 2014 оны /.../ сарын /.../ өдөр хүртэл /.../ / сарын туршилтын хугацаатай байгуулаа. Туршилтын хугацаа дуусамагц Хөдөлмөрийн дотоод журмын 4.5-д заасны дагуу гэрээний хэрэгжилтийг дүгнэн үндсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулаа.

2.2. Ажилтан тус телевизэд /.../ мэргэжлийн дагуу -тус /.../ ажилласаар /.../ нийтлэг ажил, хариуцлага, нэр хүнд, үнэ хүнийг /.../ хамгаалах, эрүүл ахуй, техникийн болон галын аюулгүй байдлын дүрэм зааврыг чанд мөрдөж ажиллана.

2.3. Ажилтны ажлын байр /.../ -д оршино.

2.4. Ажил олгогчийн даалгасан ажил, үүргийг зөвхөн энэ гэрээгээр эрхэлж буй ажил үүргийн хүрээнд биелүүлнэ.

2.5. Сарын үндсэн цалин /.../ төгрөг, бусад нэмэгдэл хэлс /.../ төгрөг байна.

2.6. Ажил олгогч цалин сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд 2 удаа хассавар бэлгээр эсхүл картвар олгоно.

2.7. Хөдөлмөрийн нөхцөл /.../ хэвийн нөхцөл хэвийн бус нөхцөл /.../ дуогуур зураг/

2.8. Ажилтан ажлын өдөр 8 цаг, долоо хоногт 40 цаг ажиллана.

2.9. Телевизийн эфир тасралтгүй байх, өдөр тутмын үйл ажиллагаа явуулах хэвийн нөхцлийг хангах үүднээс илүү цагаар ажиллуулж болно.

2.10. Ажилтан нь тогтмол ажлаасаа болон захиргааны шийдвэрээр тогтоосон ажлын цагаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцорсон минутыг цаг, цагийг хоногт шилжүүлж тухайн сарын ажлын цагаас хасаж, Хөдөлмөрийн тухай тухай хуулийн 131.1. Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1-д заасан арга хэмжээг шат дараалан авна.

Гурав. Ажилтны эрх, үүрэг

3.1. Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийг чанд салж, шударгаар ажиллах.

3.2. Ажилтан өөрийн үүрэг ажлыг мэргэжлийн зохих түвшинд хийж гүйцэтгэх ба ажил олгогчийн нэр хүндийг өндөрт өргөн ажиллах.

3.3. Телевизийн үйл ажиллагаатай холбоотой албаны нууцыг бусдад задруулахгүй, алдахгүй байх үүргийг хүлээж, нууцын зааврыг чанд мөрдөж ажиллана.

3.4. Албаны нууцад дараах зүйлүүд хамаарна. Үүнд: Телевизийн удирдлагын зүгээс нууцын жагсаалтад хамааруулсан баримт бичиг, санхүүгийн баримт, журам зааврууд, телевизийн нэвтрүүлгийн бодлого, чиглэл, бизнес төлөвлөгөө болон "Архив, нууцын журам"-д заасан бусад материал хамаарна.

Нэг. Нийтлэг үндэслэл

(Ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулах, талуудын нийтлэг эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох)

Хоёр. Ерөнхий нөхцөл

(Гэрээний үргэлжлэх хугацаа, ажилтаны үүрэг, ажлын байр, цалин, ажил амралтын цаг)

Гурав. Ажилтны эрх, үүрэг

(Дотоод журам, холбогдох хуулийн дагуу ажиллах, үүрэгт ажил, байгууллагын нууц задруулахгүй байх, хамт олны уур амьсгалыг өндөр байлгах... гэх мэт)

Ажилтан нь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, техникийн болон галын аюулгүй байдлын дүрэм зааврыг чанд мөрдөж ажиллана

Дөрөв. Ажил олгогчийн эрх, үүрэг

(Ажилтны гэрээний биелэлтэд хяналт тавих, ажиллах нөхцөл боломжоор хангах, сургалтад хамруулах, ажлын багаж хэрэгслээр хангах, цалин, амралтын мөнгө бодох... гэх мэт)

Тав. Хөдөлмөрийн гэрээ цуцлах нөхцөл

Зургаа. Бусад зүйл

Судалгаанд оролцогчдоос хөдөлмөрийн гэрээнд ажилтныхаа аюулгүй байдлын тухай ямар заалт оруулсан байдаг талаар тодруулахад байгууллагын нууц, ажлын хариуцлага гэх зэрэг байгууллагад хохирол учрахаас урьдчилан сэргийлсэн заалтууд байхаас биш сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх заалт байхгүй тухай ярьсан.

Ерөөсөө редакц, сэтгүүлч 2-ын гэрээг үзэхэд бол аюулгүй байдал гэсэн өгүүлбэр ч байхгүй, үг ч байхгүй. Ажил таслахгүй байх, редакцийн дотоод журмыг сахиж ажиллах, байгууллагын нууц задруулахгүй байх зэрэг заалтууд л байдаг. Даатгал гэдэг нь нийгмийн даатгал л байдаг байх.

57 настай, эрэгтэй

Зарим байгууллагын тухайд сэтгүүлч нь бичсэн нийтлэл, нэвтрүүлгээсээ болж аюулгүй байдалд нь заналхийлэл учирсан бол гэрээтээр хамгаалалтын албатай хамтран ажиллаж, хэсэг хугацаанд хамгаалалтад байлгадаг.

Бичсэн нийтлэл, нэвтрүүлгээсээ болж аюултай байдалд орвол хамгаалалт авах эсэх талаар редакц дотроо ярилцдаг. Шаардлагатай тохиолдолд хамгаалагч гаргаж өгнө.

33 настай, эмэгтэй

Ихэнх тохиолдолд тухайн сэтгүүлчийн гэр бүлийн хүн, эсвэл ойр дотны хүн нь эрсдэлээс хамгаалдаг гэж байлаа.

Одоо жишээ нь, миний хувьд гэхэд л аюулгүй байдлыг бол нөхөр л хангаж байна шүү дээ. Өглөө, орой зөөж өгнө, ялангуяа ноцтой асуудлуудын үед бол ганцааранг чинь явуулахгүй гээд л, иймэрхүү л байна.

35 настай, эмэгтэй

Танай байгууллагад ажилтнууддаа зориулсан аюулгүй байдлын баримт бичиг бий юу? Гэж асуухад судалгаанд оролцогсдын 26 хувь нь тийм, 45 хувь нь үгүй, 29 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан.

Томоохон редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага ХАБЭА-ын сургалтыг мэргэжлийн компаниас авч, сургалтад хамрагдсан хүмүүсээ сертификатжуулан, дараа дараагийн ажилтнууддаа компаний дотоод сургалтын хүрээнд мэдлэг олгодог. Энэхүү сургалтыг зарим сэтгүүлчид аюулгүй байдлын сургалт, баримт бичиг гэж ойлгох явдал цөөнгүй байна.

ХАБЭА-ын сургалтыг мэргэжлийн компаниудтай хамтраад ажилтнууддаа хийдэг. Сургалтанд ерөнхий менежер, албадын дарга нар хамрагдаад үнэмлэх, сертификаттай болчихдог. Дараа нь дараагийн хүмүүстээ хөдөлмөрийн аюулгүй байдлынх нь чиглэлийг өгөөд явж байгаа болохоос биш яг сэтгүүлчийн аюулгүй байдал тал дээр бол байхгүй.

31 настай, эмэгтэй

Хэвлэл мэдээллийн байгууллага эрсдэлтэй томилолтод явж буй сэтгүүлчээ шаардлагатай даатгалд хамруулдаг уу? гэж асуухад судалгаанд оролцогчдын 20 хувь тийм, 50 хувь нь үгүй, 30 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан. Даатгалд хамруулдаггүй шалтгааныг хэвлэл мэдээллийн байгууллагын хэмжээ, цар хүрээ, тухайн байгууллагын санхүүгийн чадамжтай холбож тайлбарлаж байлаа.

Ажилтан томилолтоор явахдаа онгоцоор явах тохиолдолд амь даатгал хийлгэх, хөдөлмөрийн гэрээнд хавсаргадаг ажлаас гэр хүртэлх явах замын талаарх мэдээлэл зэргийг сэтгүүлчид шаардлагатай даатгалд хамрагдсан гэж ойлгож байна.

Магадгүй МИАТ-ын даатгалд л даатгуулдаг шүү дээ. Сэтгүүлч нар чинь ийшээ тийшээ явахад онгоцны даатгалаас өөр юм байдаггүй.

37 настай, эрэгтэй

Монцамэ-д бол ноднин тухайн албан тушаалтан гэрээсээ гараад ажил хүрэхэд хичнээн зам огтолж ирж байна, энэ замдаа бэртвэл, машинд дайруулбал, ажилд ирж, буцах энэ хоорондоо осолдвол, бидэнд баримтжуулаад ирвэл тэр дагуу чинь байгууллагаас мөнгийг нь гаргаж, эмчилгээ хийлгэж өгье гэдэг гоё юм гарч ирсэн юм. Одоо бусад редакциуд баримталж байгаа.

57 настай, эрэгтэй

Мөн редакцийн том, жижиг байхаас шалтгаалан цалин хугацаандаа тавигдах нь хэвлэл мэдээллийн байгууллагын давуу тал болсон энэ үед нэмж ямар нэг даатгалд байгууллагын зүгээс хамруулах нь илүү зардал гэж сэтгүүлчид ярьсан.

Ер нь л яг эдийн засагтайгаа л холбоотой шүү дээ. Сэтгүүлч нар өөрсдөө энэн дээр анхаарал тавих ёстой л юм шиг байгаа юм. Зүгээр наад зах нь нийгмийн даатгалаа төлөхгүй ээ, гар дээрээ авдагаа нэмээд авъя гээд байгууллагатайгаа ойлголцоод явж байгаа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага бол юун тэр нэмж даатгалд мөнгө төлөх, аюулгүй байдлыг хангаад, нарийн ширийн зардал гаргах...

35 настай, эмэгтэй

Том редакцитай газруудад даатгал байхаас биш манай дээр бол яг тусгайлан даатгалд хамруулсан юм байхгүй. Хөдөлмөрийн гэрээн дээр хуулинд байдаг нэг ерөнхий заалтууд л байгаа байлгүй дээ. Яг үнэндээ санахгүй байна.

55 настай, эмэгтэй

3.4 СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮД ХЭРХЭН ХӨНДӨЖ БАЙНА ВЭ

Хураангуй

- 2 жилийн хугацаанд сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар хөндсөн 126 мэдээллийг мониторингийн явцад бүртгэж авчээ.
- Сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг www.dnn.mn, www.news.mn, www.zindaa.mn, www.eagle.mn, www.ikon.mn, www.medee.mn, www.olloo.mn, www.gogo.mn, www.montsame.mn, www.ardchilal.mn, www.arslan.mn, www.tv5.mn зэрэг мэдээллийн сайтууд бусдаасаа олон давтамжтай буюу мониторингийн хамрах хугацаанд 5-4 удаа түгээсэн байна.
- Сэтгүүлчийн аюулгүй байдал хөндөгдсөн тухай тодорхой кэйсүүд, үүнтэй холбоотой МСНЭ зэрэг мэргэжлийн байгууллагаас гаргасан мэдэгдэл болон “GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн үйл ажиллагааны тухай мэдээллүүд агуулгын хувьд голлож байжээ.


Дэлгэрэнгүй үр дүн

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр (сонин, мэдээллийн сайт) сэтгүүлчийн аюулгүй байдлын тухай хэрхэн хөндөж буйг тодруулах зорилготой. 2017.03.01-ээс 2019.03.16-ыг дуусталх хугацааг хамрав.

Хамгийн олон уншигчтай өдөр тутмын 4 сонин (Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Үндэсний шуудан) болон мэдээллийн сайтуудад дурдсан хугацаанд сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой нийт 126 мэдээлэл гарчээ. Үүний 3 нь өдөр тутмын сонинд, үлдсэн 123 нь 70 нэр бүхий мэдээллийн сайтад (хавсралт 3) нийтлэгдсэн байна.

Мэдээллийн давтамжийг нийтлэгдсэн хугацаагаар нь харвал тогтмол бус зөвхөн тодорхой үйл явдлын хүрээнд цаг үеийн байдлаар түгээгджээ. Тухайлбал, 2017 онд цөөхөн давтамжтай тогтмол бус мэдээлсэн бол 2018 онд тархалтын хувьд жигд боловч давтамжийн хувьд харилцан адилгүй 4, 7, 8, 9, 11 дүгээр саруудад олон удаа нийтлэгджээ. Доорх графикаас дэлгэрүүлэн харна уу.

График 6. Сайтад гарсан мэдээллийн давтамж



Эдгээр сайтуудаас сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг www.dnn.mn, www.news.mn, www.zindaa.mn, www.eagle.mn, www.ikon.mn, www.medee.mn, www.olloo.mn, www.gogo.mn, www.montsame.mn, www.ardchilal.mn, www.arслан.mn, www.tv5.mn зэрэг мэдээллийн сайтууд бусдаасаа олон давтамжтай буюу мониторингийн хамрах хугацаанд 5-4 удаа түгээжээ.

Эдгээр мэдээллийн дийлэнх нь (85 хувь) тухайн сайтын “Нийгэм” буланд нийтлэгдсэн бөгөөд цаг үеийн мэдээ хэлбэрээр голчлон (71 хувь) бичигдсэн байна. Хандлагын хувьд харьцангуй тэнцвэртэй өнгө аястай байв.

Мэдээллүүдийг хөндөж буй агуулгаар нь ангилж харвал сэтгүүлчийн аюулгүй байдал хөндөгдсөн тухай тодорхой кэйсүүд, МСНЭ-ээс гаргасан мэдэгдэл, шаардлагууд, “GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн үйл ажиллагааны тухай мэдээллүүд байв.

Хүснэгт 7. Сайтаар гарсан мэдээллийн агуулга

Мэдээллийн агуулга	Тоо	Хувь
Сэтгүүлчийн аюулгүй байдал хөндөгдсөнтэй холбоотой – кэйсүүд	72	59%
Мэдэгдэл, шаардлага (Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс гаргасан – 18, Олон улсын сэтгүүлчдийн холбоо -2)	20	16%
“GSP+механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрийн эрхийг хөхүүлэн дэмжих нь” төсөл (мэргэжлийн байгууллагууд хамтран сэтгүүлчдийн аюулгүй байдалд мониторинг хийж, урьдчилсан үр дүнг танилцуулсан тухай)	17	14%
Сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээлэл	11	8%
Сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой ОУ-ын мэдээлэл	2	2%
2017 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан ЮНЕСКО-гийн илгээлт	1	1%

Сэтгүүлчийн аюулгүй байдал хөндөгдсөнтэй холбоотой кэйсүүд

Мониторингийн хугацаанд 7 төрлийн кэйс бүртгэгдлээ. Эдгээр кэйсүүдийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөвхөн цаг үеийн шинжтэй мэдээ хэлбэрээр хэвлэн нийтэлжээ. Эх сурвалжийн хувьд олон талын байр суурийг хангаагүй, зарим тохиолдолд тодорхой баримт нотолгоог дэлгэн харуулсан хэлбэрээр бичигджээ. Энэ төрлийн мэдээллийн 12 хувьд эрх нь зөрчигдсөн сэтгүүлч хэвлэл мэдээллээр дамжуулан өөрөө байр сууриа илэрхийлж дуу хоолойгоо хүргэсэн байгаа нь сэтгүүлчид өөрсдийн зөрчигдсөн эрхээ хамгаалахад төдийлөн идэвхтэй, санаачлагатай бус байгааг харуулж байж болох юм.

1. “Сод Монгол” группийн хуулийн зөвлөх О, БЗД-ийн 5-р хорооны хэсгийн төлөөлөгч нар бусадтай бүлэглэн Chuham.mn сайтын редакцид халдаж, айлган сүрдүүлэх үйл ажиллагааг явуулж, сэтгүүлчдийн компьютерт хүч түрэн халдан нэгжлэг хийж, сайтын архивыг нь шүүж нэр бүхий этгээдтэй болон “Сод Монгол” групптэй холбоотой сөрөг мэдээллүүдийг түүж устгахыг шаардсан тухай (2 мэдээлэл)
2. Стандарт, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр, тус газрын зарим газар, хэлтсийн дарга нарыг гүжирдэж нэр хүндийг гутаасан хэмээн буруутгагдан Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар шүүхэд дуудагдсан www.dorgio.mn сайтын сэтгүүлч А.Баярмаатай холбоотой (20 мэдээлэл)
3. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор нэр бүхий сэтгүүлч, түүний гэр бүлийн хүмүүсийнх нь хамт тагнаж чагнасан, айлган сүрдүүлж машин руу нь буудсан гэх мэдээллийн хүрээнд холбогдох төрийн байгууллага болон сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах мэргэжлийн байгууллагуудын байр суурийг хүргэсэн мэдээ, тодруулга, сурвалжилга, ярилцлага гэх мэт (28 мэдээлэл)
4. УИХ-ын гишүүн Д.Мурат ёс зүйгүй үйлдэл гаргасан хэмээн олон нийтэд мэдээлсэн “News Channel” телевизийн сэтгүүлч Д.Майцэцэгийг бусдын нэр төрд, алдар хүнд, хувь хүний нууцад халдсан хэмээн зарим хуулийн холбогдох заалтаар буруутгагдан шүүхэд дуудагдсан тухай (7 мэдээлэл)
5. Хотын менежер Т.Гантөмөр ажил үүргээ гүйцэтгэж явсан «UBS» телевизийн зураглаачийн биед халдаж танхайрсан, тухайн газраас сэтгүүлчийг хөөн гаргасан тухай (2 мэдээлэл)
6. Монгол-Туркийн хамтарсан сургуулийн дэд захирал Вейсэл Акчайг хулгайлсан гэх асуудлыг сурвалжилж олон нийтэд хүргэхээр сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулж байсан “Ийгл ньюс” телевизийн сэтгүүлч Б.Батцэцэгийн биед Эрүүгийн цагдаагийн газрын төлөөлөгч санаатайгаар халдаж, шанаа руу хүчтэй цохисон тухай (14 мэдээлэл)
7. АНУ-ын иргэн, зэвсэгт хүчний хошууч М.Стюарт Улаанбаатар дахь Шангри-Ла зочид буудлын өрөөнд өөрийгөө боомилсон байдалтай нас барсан талаарх мэдээллийг сурвалжлахаар очсон “Засгийн газрын мэдээ” сонины сэтгүүлч Э.Батцэцэг, фото сэтгүүлч С.Батсайхан нарыг зураг авлаа гэсэн үндэслэлээр биед нь нэгжлэг хийж, утсан дээрх зургийг устгасан, зурагчны

гэрэл зургийн аппаратыг хураан авч, баривчилсан гэх мэт (3 мэдээлэл)
Жишээ болгож кэйсүүдийн зарим зургийг хавсралт 21-с харна уу.

Дээрх үйл явдлууд тохиосонтой холбоотойгоор МСНЭ болон Олон улсын сэтгүүлчдийн холбооноос мэдэгдэл гаргажээ. Тус мэдэгдлийн агуулга нь сэтгүүлчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлж ажилласны төлөө дарамт, шахалтад өртөж, ял тулгагдаж буйг эсэргүүцээд, чөлөөт хэвлэл, сэтгүүл зүйн мэргэжлийн эрх ашиг, сэтгүүлчийн хууль ёсны үйл ажиллагааг хамгаалахын төлөө хамтдаа тэмцэж, нэгдэж ажиллахыг уриалсан байв. (Хавсралт 22)

Харин сэтгүүлчийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах, түүний үр нөлөө, ач холбогдлын талаар мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллага бусад эрх бүхий институциуд, судлаачид, хүний эрхийн идэвхтнүүдийн дуу хоолой бага байв. Мөн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдад зориулан мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулснаас үүдэж бусдаас ирж буй дарамт шахалт, аюул заналхийлэл, айлган сүрдүүлэлт, давуу байдлаа ашиглан хүч түрэмгийлж бие махбод, ажлын хэрэгсэлд нь халдсан тохиолдолд хэнд хандах, хэрхэн зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, ямар боломж байдаг эсэх талаарх зөвлөмж, зөвлөгөө, ойлголт мэдлэг өгөх мэдээлэл огт гараагүй байлаа.

Өдөр тутмын сонинд нийтлэгдсэн дараах 3 мэдээлэл нь мэдээллийн сайтуудад нийтлэгдсэнтэй агуулгын хувьд давхцаж байв.

- “Өнөөдөр” сонин 2018.04.27-ны дугаарт “Сэтгүүлчдийг тагнасан гэх цагдаагийнхныг яллагдагчаар татах санал хүргүүлжээ”
- “Зууны мэдээ” сонинд 2018.04.09-ний дугаарт “Стандарт, хэмжил зүйн газрын удирдлагуудаас зарим сайт уучлал гуйжээ”
- “Зууны мэдээ” сонин 2018.04.27-ны дугаарт “Сэтгүүлчдийг тагнасан, чагнасан, буудсан гэв үү” гэсэн нэртэйгээр гарсан.

3.5 ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ БОЛОН СЭТГҮҮЛЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ХУУЛЬЧДЫН САНАЛ БОДОЛ

Хураангуй

- Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх боломж бүрдсэн, гэвч энэхүү эрх нь хуулиар олгогдсон, хуулийн хүрээнд хэрэгжих ёстой эрх болохоос биш энэ эрх хэн нэгнийг гүтгэх, доромжлох байдлаар хэрэгждэг, ямар ч хэмжээ хязгааргүй эрх биш гэж шүүгчид үзэж байна.
- Олон талт байр суурьтай хүмүүс хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж шүүхийн хянан шийдвэрлэх үйл ажиллагаа болон шүүхийн шийдвэрт нөлөөлөх гэж оролддог. Гэвч шүүх процесс нь зөвхөн хуулийн хүрээнд, хуульд заасан хэм хэмжээний дагуу явагддаг учир хэвлэл мэдээллийн хэрэгсэл шүүхийн шийдвэрт нөлөөлөх боломжгүй гэж тэд үзэж байна.
- Харин хэвлэл мэдээллээр түгэж буй элдэв мэдээлэл нь шүүн таслах ажиллагаа гэхээс илүүтэй шүүгчийн нэр хүндийг унагахад хүргэдэг. Гэвч шүүгчид төдийлөн гомдол гаргаад байдаггүй. Учир нь шүүгч өөрийгөө буруугүй гэдгээ тайлбарлахын тулд хэргийн материалд авагдсан бүх баримтыг задлах шаардлага үүснэ. Энэ нь зохисгүй үйлдэл тул нэр хүндээрээ хохироод явах сонголт үлддэг гэжээ.
- Хууль ёсны дагуу хийж байгаа сэтгүүлчийн үйл ажиллагааанд ямар ч субъект халдахгүй. Мэдээллийн эх сурвалж тодорхой, үнэн зөв байгаа тохиолдолд сэтгүүлчид хуулийн хариуцлага хүлээлгэхгүй. Харин эх сурвалжгүйгээр хэн нэгнийг гүтгэх доромжлох үйлдэл хийсэн бол тэдэнд хуулийн хариуцлага үүрүүлэх тухай яригдана.
- Ярилцлагын судалгаанд хамрагдсан шүүгчид Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг шүүхийн шийдвэр гаргахдаа хэрэглэж байсан тохиолдол байхгүй байна. Түүнчлэн Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт дахь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг заасан хэсэг болон Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль дахь холбогдох заалтуудын хоорондын уялдаа холбоог хэрхэн тайлбарлах тал дээр шүүгчид тодорхой хариулт өгөөгүй.
- Хэвлэл мэдээллийн салбар улс төр, бизнесийн ашиг сонирхлоос хол байж, сэтгүүлчид мэргэжлийн түвшинд, хараат бус, ёс зүй, хэм хэмжээгээ сахиж ажиллаж чадвал элдэв аюулаас хамгаалагдаж чадна гэж шүүгчид үзэж байна.

Дэлгэрэнгүй үр дүн

1. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй, хорио саадгүй илэрхийлэх эрхийн баталгаа хэр бүрдсэн гэж үздэг вэ?

Судалгаанд оролцсон шүүгчид Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажсан **үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх боломж хүн бүрт бүрдсэн** гэж үзэж байна. Гагцхүү тэр эрхээ хэрхэн эдэлж буй нь тусад нь авч үзэх ёстой асуудал гэжээ.

Хүн бүр Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх боломж бий. Гэхдээ энэ эрхээ хэт хязгааргүй эдэлж байгаад асуудал байна. Хүнд хардах эрх бий. Ямар ч эх сурвалжгүйгээр энэ яг ингэсэн, ингэсэн л байж таараа гээд харддаг, тэр нь гүтгэлгийн шинж рүүгээ ордог.

Шүүгч

Нэг сэдэв гараад түүнийг 2 талаас нь ярьж байгаа бол үзэл бодлоо илэрхийлж байна гэж үзнэ. Гэтэл нэг сэдэвт хамааруулаад хэн нэгэнрүү дайраад байвал тэр үзэл бодлоо илэрхийлж буй байдал мөн үү?

Шүүгч

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хуулиар олгогдсон, хуулийн хүрээнд хэрэгжих ёстой эрх болохоос биш энэ эрх хэн нэгнийг гүтгэх, доромжлох байдлаар хэрэгждэг, **ямар ч хэмжээ хязгааргүй эрх биш** гэж шүүгчид үзэж байна. Түүнчлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах асуудал хуулийн салбарын хувьд, төрийн албан хаагчдын хувьд дутагдалтай байдаг. Яагаад вэ гэхээр хуулиараа өөрийнхөө үзэл бодлыг, ялангуяа улс төрийн шинжтэй асуудлаар илэрхийлэхийг хорьсон байдаг гэжээ.

2. Хэрэг маргааны шүүхээр шийдвэрлэх ажиллагаан дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө

Шүүхийн тодорхой үйл ажиллагааны явцад, жишээ нь хурлын явцыг хэвлэн нийтлэх, мэдээлэх эрх нээлттэй. Жишээ нь шүүх хурал хойшлох, завсарлах зэрэг асуудлыг иргэд бичлэг хийгээд нээлттэй мэдээлэх боломж бүрдсэн. Гэвч тодорхой хэрэг маргааныг улс төржүүлдэг, мушгин гуйвуулдаг. **Үүндээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж, олон нийтэд нөлөөлөх гэж үздэг тохиолдол нэлээн бий. Гэхдээ энэ нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрт нөлөөлөхгүй** гэж шүүгчид үзэж байна.

Шүүн таслах ажиллагаанд 2 зүйл байдаг. Нэгдүгээрт ямар үйл баримт болсныг тогтоох, хоёрдугаарт хуулийг болсон процесст буулгаад хэргийг шийдэх. Шүүгч хүн энэ сайн хууль, энэ муу хууль гээд зарим хуулийг хэрэглэхээс татгалзах эрхгүй. Шүүгч ийм л ажил хийнэ. Түүнээс биш олон нийт ингэж үзэж байна гээд шийдвэрээ өөрчлөх боломжгүй гэдгийг нийгэм ойлгодоггүй. Хуулиа тэр чигээр буулгаад шийдвэр гаргана, тэр нь харин нийгэмд хэрхэн нөлөөлөх нь өөр асуудал гэж шүүгчид өгүүлж байна.

Шүүгч хүн шийдсэн хэргийнхээ талаар хэвлэлд мэдээлэл өгдөггүй, Үүнийг маш их далимдуулдаг. Жишээ нь улс төрч холбогдсон хэргийг шийдлээ гэхэд тухайн улс төрч өөрөө намайг шүүгч ингэж ингэж шийтгэлээ гээд хэвлэлээр яриад явдаг. Гэтэл тухайн хэрэгт холбогдох хавтаст хэрэгт юу юу байгаа, ямар нотлох баримт байгаа талаар ард иргэд мэддэггүй. Шүүгч зөвхөн хавтаст хэрэгт байгаа хуульд заасны дагуу бэхжүүлж, цуглуулж авсан нотлох баримтад үндэслэн хөндлөнгийн байр сууринаас шийдвэрээ гаргадаг.

Шүүгч

3. Хэвлэл мэдээллийн орчинд олон тооны мэдээлэл, тэдгээр мэдээлэлд үнэлэлт дүгнэлт өгч буй эерэг, сөрөг үзэл бодол их байна. Дээрх нөхцөл байдлын улмаас хэн нэгний алдар нэр, нэр хүндэд халдсан хэрэг маргаан хэр зэрэг гардаг вэ?

Энэхүү нөхцөл байдал нь хүний алдар нэр, нэр хүндэд маш ихээр халдаж байна. Харин түүнийг тэр бүр шүүхэд аваачаад байх нь ховор байдаг гэж шүүгчид үзэж байна.

Шүүгчдийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараагдаж буй мэдээлэл нэргүй, эсхүл нууц нэрээр нийтлэгддэг, нотлох баримтгүй, яагаад ингэж үзэж байгаагаа тайлбарлаж бичдэггүй байдалд шүүмжтэй хандаж байна. Энэ байдал нь эргээд мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзээ үүсгэдэг. Худал, гүтгэлгийн болон доромжилсон шинжтэй нийтлэл, коммент нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх хэлбэр биш гэж үзэж байна.

Ерөнхийдөө сошиалаар тарааж буй ташаа мэдээлэл хэт хавтгайруулсан шинжтэй байдаг. Тухайн мэдээлэлд өгч буй санал буюу коментууд бол бүр ямар ч ойлголтгүй, мэдээлэлгүй байж гүтгэх шинжтэй байдаг. Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийн хувьд нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг. Хүнийг гүтгэх гэдэг бол өөрөө гэмт хэрэг юм. Тэгэхээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэдэг нь арай өөр ойлголт юм шүү гэдгийг ард түмэнд ойлгуулах хэрэгтэй.

Шүүгч

Шүүгчдийн хувьд үүнд маш их өртдөг гэж хариулсан байна. Гэвч шүүгч нэр төрөө хамгаалахаар төдийлөн гомдол гаргаад байдаггүй, ингэхийг зохимжгүй зүйл гэж үздэг.

Өнөөдөр миний нэр хүндэд халдлаа гээд гомдол гаргаад явдаг шүүгч байхгүй. Ийм гомдол гаргах нь зохимжгүй. Шүүгч өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргана. Шийдвэр гаргахдаа мөрдөгч, прокурорын цуглуулсан нотлох баримтыг үнэлнэ. Хэрэв шүүгч тодорхой хэрэг маргааны талаар ярих, өөрийгөө буруугүй гэдгээ тайлбарлах хэрэг гарвал тэр хэргийн материалд авагдсан бүх баримтыг задлах, тэр тухай бас ярих шаардлага үүснэ. Иймээс шүүгч нэр хүндэд халдсан гээд гомдол гаргаад явах нь зохимжгүй байдаг. Үүнтэй холбоотойгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь тодорхой хэмжээнд хязгаарлагдмал байдаг шүүгчийг бас хэвлэл мэдээллийн хэрэгслээр дайрч доромжлох нь зохимжгүй байгаа юм.

4. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэвлэн нийтлэх эрх чөлөөгүйгээр төсөөлөх аргагүй. Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх заяагдмал эрх болон хэвлэл мэдээллийн байгууллагын (сэтгүүлчийн) мэдээлэх зайлшгүй үүргийн ялгаатай талыг хэрхэн ойлгож байна вэ?

Судалгаанд хамрагдсан шүүгчид хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх заяагдмал эрх болон хэвлэл мэдээллийн байгууллагын (сэтгүүлчийн) мэдээлэх үүргийн ялгаатай байдлын талаар өөр өөрсдийн үзэл бодлоо хуваалцсан. Түүнийг товч сийрүүлбэл **"Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх заяагдмал эрхийг тухайн хүн зөвхөн өөрт хамааралтай асуудлын хүрээнд эсхүл тодорхой нэг сэдэвт холбогдуулан үзэл бодлоо илэрхийлэх явдал"** гэж үзжээ.

Харин хэвлэл мэдээллийн байгууллагын (сэтгүүлчийн) мэдээлэх үүрэг нь нэгдүгээрт, тухайн мэдээллийг хүргэхгүй байснаараа иргэдийн мэдэх эрхийг зөрчинө; хоёрдугаарт, худал мэдээлэл дамжуулснаараа иргэдийн үнэн мэдээлэл авах эрхийг зөрчинө; гуравдугаарт, үнэн мэдээллийг гаргахгүй байснаар худал мэдээллийг үнэн мэдээллээс ялгахгүй байх нөхцөл байдлыг үүсгэнэ гэсэн хүрээнд мэдээллээ хүргэх хэрэгтэй гэж хардаг байна.

Мэдээллийн хувьд үнэн бодитой, эх сурвалжтай байх хэрэгтэй. Хэн нэгэн муу юм хийсэн байж болно, тэгвэл нотлох баримттай, эх сурвалжтай байх хэрэгтэй. Нотлогдоогүй байхад ташаа мэдээлэл өгөх нь, урьдчилж таамаглах, урьдчилж шийдвэр гаргаад явах нь зохимжгүй гэж хариулсан байна.

Харин хэвлэл мэдээллийн байгууллагын (сэтгүүлчийн) мэдээлэх үүрэг, мэдээллийн агуулгад төлбөртэй болон **захиалгат мэдээллийг ямар ч цензургүйгээр түгээж байгаад анхаарал хандуулах шаардлагатайг** сануулж байна.

5. Сэтгүүлчид мэдээлэх үүргээ (ажил үүргээ) гүйцэтгэсэн үйлдэлд нь хуулийн хариуцлага хүлээлгэх нь тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд нь халдаж байгаа хэрэг мөн үү?

Хууль ёсны дагуу хийж байгаа сэтгүүлчийн үйл ажиллагаанд ямар ч субъект халдахгүй. Мэдээллийн эх сурвалж тодорхой, үнэн зөв байгаа тохиолдолд сэтгүүлчид хуулийн хариуцлага хүлээлгэхгүй. Харин эх сурвалжгүйгээр хэн нэгнийг гүтгэх доромжлох үйлдэл хийсэн бол энэ асуудал яригдана гэж хариулсан байна.

6. Иргэний болон улс төрийн олон улсын пактын хэрэглээ, хэрэгжилтийн тухай

Ярилцлагын судалгаанд хамрагдсан шүүгчид Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг шүүхийн шийдвэр гаргахдаа хэрэглэж байсан тохиолдол байхгүй байна. Түүнчлэн Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт дахь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг заасан хэсэг болон Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль дахь холбогдох заалтуудын хоорондын уялдаа холбоог хэрхэн тайлбарлах тал дээр шүүгчид тодорхой хариулт өгөөгүй. Пактын хэрэглээг нэмэгдүүлэх шаардлага бий гэж хардаг боловч хэрхэн

хэрэглэх талаар тодорхой саналгүй байна.


Шүүгчид шийдвэр гаргахдаа аливаа төрлийн олон улсын гэрээ, конвенцийг тэр бүр ашиглаад байдаггүй байна. Ихэнхдээ дотоодын хууль тогтоомжийг ашигладаг бөгөөд иргэний эрх зүйн маргааны үед гэрээнд олон улсад ашиглагдаж буй гэрээ, конвенцийг хэрэглэхээр тусгасан тохиолдолд ашигладаг байна. Түүнчлэн олон улсын гэрээ, зохицуулалт нь манай улсын нийгэм, эдийн засгийн байдал, ахуй, соёл заншилтай төдийлөн нийцэхгүй байх болон албан ёсны орчуулгатай тулгаж хэрэглэхгүй бол ойлголтын зөрүү гарах магадлалтай байдаг аж.

Санал асуулгын судалгаанд оролцогсдын 76 хувьд нь эрхэлж буй ажлынхаа хүрээнд олон улсын гэрээ, конвенц хэрэглэх шаардлага гардаг гэжээ. Гэхдээ зөвхөн шаардлагатай тохиолдолд, цөөн удаа хэрэглэдэг аж. (71 хувь)

Харин Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг хэрэглэж байсан тохиолдол тэдний 18 хувьд нь тохиолдож байсан байна.

Оролцогчдыг олон улсын гэрээ конвенцийн талаарх өөрийн мэдлэгээ 1-10 оноогоор үнэлэхийг хүсэхэд дийлэнх нь 3-5 гэсэн оноог өгч байв.

График 7. Олон улсын гэрээ, конвенцийн талаарх өөрсдийн мэдлэгээ үнэлсэн байдал



7. Сэтгүүлчийн аюулгүй байдал ямар түвшинд байна вэ?

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдээс ангид, хараат бусаар ажиллаж, хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээгээ сахиж чадвал тодорхой хэмжээнд хамгаалагдсан гэж зарим шүүгчид харж байна.

Ерөнхийдөө хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хэн нэгэн эрх мэдэлтний буюу тэр намынх, тэр улс төрчийнх гэдэг томьёолол зүүтлээ нөлөөлөлд автсан, тэдгээрээр цацагдаж буй мэдээллийн дийлэнх хувь нь ямар нэг улс төрийн хүчин, улс төрчид хамааралтай байгааг сануулж байна. Улс төрчдийн цаана эдийн засгийн бүлэглэлүүд байна. Иймээс хэрэв тэдэнд таалагдаагүй мэдээлэл нийтэлсэн тохиолдолд сэтгүүлчид халдах явдал гарахыг үгүйсгэхгүй байна.

Түүнчлэн засаглалын 4 дэх хэлбэр болох хэвлэл мэдээллийн хэрэгсэл арилжааны талруугаа явсан, мөнгө олох хэрэгсэл болсон нь үнэн, зөв мэдээлэл түгээх үндсэн

зорилгоо мартаход нөлөөлдөг. Тухайлбал, хэт олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгаагаас мэдээлэл олж авах, түүнийгээ аль болох сенсаци болгохын тулд сэтгүүлчдийн дундах өрсөлдөөн маш өндөр байна. Үүний зэрэгцээ тухайн мэдээлэлд дурдагдсан хүн рүү утасдаад ийм тийм мэдээлэл байна гээд тэр нь тэгээд нийтэлж болох, болохгүйг нь шийдээд мөнгө амлах, худалдах, хаалтын гэрээ хийх зэргээр амжиргаагаа залгуулж байгаа нь сэтгүүлчид өөрсдийн эрх ашиг, аюулгүй байдалд халдах шалтгаан болох эрсдэлтэй гэж харж байна.

Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимтай. Гэтэл тухайн сэтгүүлчийн, хэвлэл мэдээллийн хэрэгслийн гэм буруутай эсэхийг тогтоогоогүй байж эрхийг нь хаах гэдэг бол байж болохгүй зүйл гэж бодож байна. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзэж л байгаа бол шүүхэд хандах хэрэгтэй, шүүхээр гэм буруу нь тогтоогдсоны дараа л эрх хязгаарлах, хаах уу үгүй юу гэдэг асуудлыг ярих ёстой

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

- Монгол улс үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх болон мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөөг баталгаажуулсан олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд элсэн орж үүрэг хүлээсэн төдийгүй дотоодын суурь хуулиудыг ч баталсан байна. **Гэвч дээрх эрх, эрх чөлөөнд саад болохуйц хэд хэдэн хязгаарлалтууд байгаа** нь анхаарал татаж байна.
- Нэр төр гутаах, доромжлох үйлдэл болон гүтгэлгийг эрүүгийн хэрэгт тооцохгүйгээр Иргэний хуульд зааснаар иргэний хэргээр шийдэж болохоор зохицуулсан. Гэвч, **“Гүтгэх” хэрэг нь эрүүгийн хэрэг биш Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил болох бөгөөд, Эрүүгийн хуульд гүтгэлэгтэй төстэй зохицуулалтууд** энд үлджээ. Сэтгүүлчдийн дунд явуулсан судалгаагаар гурван сэтгүүлч тутмын нэг нь Зөрчлийн тухай хуулийн дагуу шүүх, цагдаагийн байгууллагад дуудагдаж байна гэжээ. Гүтгэх, доромжлох асуудлыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх болсонтой холбогдуулан цагдаагийн ажилтан сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хориглох, саад болох тохиолдол илэрч байгаа нь судалгааны явцад ил болсон. 2017 он, 2018 оны эхний 3 сарын байдлаар Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлөөр 46 сэтгүүлч буруутгагдсан байна.
- Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар болон Цагдаагийн байгууллага өөрсдийн хамаарах хүрээнд дүгнэлт гаргах бөгөөд тэдгээрт үндэслэж болон бусад хууль, журмын хүрээнд радио, телевиз, цахим сайтын хандалтыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо эрхэлдэг. Хэдийгээр төрийн ямарваа нэгэн хэлбэрийн цензур хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавихыг хуулиар хориглосон ч (Хэвлэл Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйл) дээрх тохиолдолд **төрийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэвлэл мэдээллийн зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалт Монгол Улсад хэвээр байна.** Соёлын тухай хууль дахь “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт”, Сонгуулийн тухай хуулийн “..хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай ашиглан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараахыг хориглосон...” тухай зүйл заалт нь **хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт юм.**
- Эрүүгийн хуулийн 14.2, 14.3 болон Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 2, 3 дугаар зүйлүүд нь нууцын зэрэгтэй зүйлсийг хадгалах үүрэгтэйг тодорхой заасан байна. **Гэвч байгууллагын нууцад юуг хамааруулахыг тухайн байгууллагын удирдлага шийддэг нь учир дутагдалтай,** маш их мэдээллийн нуун

дарагдуулах эрсдлийг дагуулж, мэдээлэл авах эрхийг зөрчсөн хэрэг хэмээн сэтгүүлчид үзэж байна.

- Мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хууль болох Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд олон улсын аргачлалаар үнэлгээ хийхэд хангалтгүй үнэлгээг авсан, төрийн албан тушаалтан тус хуулийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын долоод нь тохиолдсон бөгөөд **ийнхүү татгалзах гол шалтгаан нь Нууцын тухай хууль байгааг** анхаарахгүй өнгөрч болохооргүй байна.
- Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх төрлийн цензур 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Хэвлэл мэдээллийн байгууллага нь өөрөө томоохон бизнесийн бүлэглэл, улс төрчдийн эзэмшилд байгаа, сэтгүүлчдийн цалингийн хэмжээ бага, зарим сэтгүүлчдийн өөрсдийнх нь ашиг сонирхол харсан үйлдэл нь энэ мэт зүйлсийг дэвэргэж байна гэж сэтгүүлчид үзэж байна. Мөн шүүгчдийн зүгээс энэ санааг давтаж байсан бөгөөд **хэвлэл мэдээллийн салбар улс төр, бизнесийн ашиг сонирхлоос хол байж, сэтгүүлчид мэргэжлийн түвшинд, хараат бус, ёс зүй, хэм хэмжээгээ сахиж ажиллаж чадвал элдэв аюулаас хамгаалагдаж чадна** хэмээсэн юм.
- Бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод гурван сэтгүүлч тутмын хоёр нь ямар нэг хэлбэрийн сүрдүүлэг, дарамт, заналхийлэлд өртөж байна. Мөн бие эрхтэнд болон ажлын багаж хэрэгсэлд халдах тохиолдол ч цөөнгүй байна. Гэвч **эрх нь зөрчигдсөн сэтгүүлчид тэр тухайгаа олон нийт, мэргэжлийн байгууллагад мэдэгддэггүй**, зөрчлийг ноцтой биш, их хэмжээний хохирол амсаагүй гэж үзсэн үедээ цагдаагийн байгууллагад гомдол гаргаад байдаггүй байна. Нэг талаас үүнийг цагаа үрсэн явдал гэж үздэг, нөгөө талаас **сэтгүүлчид өөрсдөө хууль, эрх зүйн мэдлэг муу, ямар нэг байдлаар шүүх цагдаагийн байгууллагад дуудагдахдаа өмгөөлөгч, нийгмийн байгууллагаас зөвлөгөө авах тал дээр дутмаг** байдагтай холбоотой.
- Ажил олгогч (удирдлага), ажилтан (сэтгүүлч)-тай байгуулсан **хөдөлмөрийн гэрээнд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах талаар дийлэнх тохиолдолд тусгагддаггүй**, даатгал төлөхөөс илүүтэй даатгалд зарцуулах зардлыг цалин, урамшуулал хэлбэрээр авахыг тэргүүнд тавьдаг байна. Энэ нь сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах дээр аль аль талдаа санаачилга, зүтгэлгүй байгааг харуулж байна. Түүнчлэн **сэтгүүлчийн аюулгүй байдлыг хэрхэн хангах тухай зөвлөмж, туршлагын тухай бичиж, нийтлэх ч үгүй** байна.
- Эрх мэдэл бүхий албан тушаалтан, улс төрчийн нэр хүндэд халдсан, баримтын алдаа гаргасан, бодит байдлыг гэмт хэргийн шинжтэй бичсэн гэх зэрэг шалтгаанаар шүүх, цагдаагийн байгууллагад дуудагддаг

хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь ямар нэг шийтгэл хүлээх, тэр дундаа **торгууль хүлээхээс зайлсхийж, бэлтгэсэн мэдээллээ устгах зэргээр зөвшилцөх явдал цөөнгүй байдаг** аж. Тэр бүү хэл редакцийн буруу тохиолдолд 20 сая төгрөгөөр торгуулахаас зайлсхийж, сэтгүүлчид хэргийг үүрүүлж, 2 сая төгрөгөөр торгуулах замыг сонгодог байна.

- Сэтгүүлчид үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хязгаарлагдаж байна хэмээн дүгнэж байгаа бол шүүгч, прокурор, өмгөөлөгч зэрэг хуулийн ажилтнууд энэ эрх хангагдсан, **гагцхүү хэрэгжүүлэх тал дээр учир дутагдалтай байж, бусдын нэр хүндэд халдах, нийгмийг худал мэдээлэлд автуулах зэргээр буруугаар ашиглаж байна** хэмээн үзэж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

- Улсын Их Хурлаас дотоодын хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд нийцүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн “Зарим төрлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглох” гэх 4 дүгээр бүлгийн 18-24 дүгээр зүйлийн зохицуулалт **хэт ерөнхий байгааг өөрчилж, бусдад задруулахыг хориглосон мэдээллийн төрлийг мэдээлэл өгөхөөс татгалзах этгээд өөрийнхөөрөө тайлбарлах боломжийг хязгаарлах** хэрэгтэй байна.
- Улсын Их Хурлаас Эх сурвалж хамгаалах, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах хууль зүйн баталгааг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 14.2 дугаар зүйлд заасан “Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах”, 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэрэг нь ангиллын хувьд **хөнгөн гэмт хэрэгт хамаарч байгааг өөрчлөн, хүнд гэмт хэрэгт хамааруулах хэрэгтэй байна**. Энэ хүрээнд дурдсан гэмт хэрэгт оноох ял шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн дурдсан гэмт хэргийг **шалган шийдвэрлэх албан хаагчдыг тусгайлан бэлтгэх** буюу харьяалал тогтоох хэрэгтэй байна.
- Төрийн байгууллага, албан тушаалтнууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах, зөрчигдөхөөс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Энэ хүрээнд Улсын Их Хурлаас Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар **иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаарх гомдлыг Комисс үр дүнтэй шалган шийдвэрлэх бүрэн эрх, хууль зүйн баталгааг бүрэн тусгах** шаардлагатай байна.
- Хууль зүй, дотоод хэргийн яам болон Цагдаагийн ерөнхий газраас гүтгэх зөрчилтэй холбоотойгоор сэтгүүлчийн үйл ажиллагаатай холбоотой **гомдлыг шалган шийдвэрлэх албан тушаалтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах** шаардлагатай байна. Энэ хүрээнд гүтгэх зөрчлийг шалгах шийдвэрлэх чиг үүрэг бүхий цагдаагийн албан хаагчдад зориулсан сургалтыг Монголын Хуульчдын холбоо, Глоб интернэшнл төв зэрэг энэ чиглэлээр мэргэшсэн олон нийтийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулж байх шаардлагатай байна.
- Шүүхийн ерөнхий зөвлөл, бүх шатны шүүхээс хэрэг, маргааны оролцогчид шүүх хуралдаанд тэгш оролцогч байх нөхцлийг хангах зорилгоор сэтгүүлчийг буруутгасан хэрэгт **сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны талд заавал өмгөөлөгч, хуульч ажиллуулахад анхаарч**

ажиллах шаардлагатай байна.

- Бүх шатны шүүхийн шүүгчдийн хувьд, гүтгэх зөрчил, нэр төр, алдар хүндийн талаарх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ маргааны зүйл буюу **үйл баримт нь олон нийтийн эрх ашгийг илэрхийлсэн эсэхийг харгалзаж байх** нь зүйтэй байна.
- Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс төрийн жинхэнэ албан хаагчид, улс төрийн зүтгэлтэн, олны танил зэрэг иргэд, олон нийтийн байнгын хяналт, хардлагад байдаг буюу тийм нөхцлийг өөрөө зөвшөөрсөн бусад этгээдийн хувьд гүтгэх зөрчил, нэр төр, алдар хүндийн талаар эрх бүхий байгууллага, шүүхэд гомдол гаргах нөхцлийг хууль тогтоомж, ёс зүйн дүрэм, бусад эрх зүйн актаар дамжуулан хязгаарлах хэрэгтэй байна.
- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Оюуны өмчийн газрын дүгнэлтээр Харилцаа холбооны зохицуулах хороо нь хэд хэдэн хууль, журмыг үндэслэн телевиз, радиогийн эрхийг түр хугацаагаар түтгэлзүүлэх, хүчингүй болгох, цахим мэдээллийн сайтын хандалтыг хааж, хязгаарлаж буй. Хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой боловч нэр томьёоны хувьд ерөнхий, тодорхойлт байхгүй, хамрах хүрээг тогтоогүй нь **хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэхээс сэргийлж үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхэд нийцүүлэн өөрчлөлт хийх шаардлагатай** байна.
- Хууль тогтоогчид болон нууцын жагсаалтыг батлах албан тушаалтнууд Төрийн болон албаны нууцын тухай хууль, журмын хүрээнд **байгууллагын нууц гэж томъёолох зүйлсийн жагсаалтыг илүү тодорхой болгох** дээр ажиллаж, иргэдийн мэдээлэл олж авах эрхээ зүй ёсоор эдлэх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид **аюулгүй байдал нь зөрчигдсөн тохиолдолд тухай бүрт нь Глоб интернэшл болон бусад байгууллагад бүртгүүлж байх**. Ийм хөшүүргээр хангах тал дээр хэвлэл мэдээллийн байгууллагууд санаачлагатай ажиллах хэрэгтэй байна. Энэ нь хуулийн төсөлд санал оруулах хийгээд, олон улсын түвшинд нөлөөлөх үүрэгтэй болохыг анхаарах нь зүйтэй.
- Хэвлэл мэдээллийн байгууллага шүүх, цагдаагийн байгууллагатай хамтран үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн тухай, уг эрхээ хэрхэн эдлэх тухай хамтарсан сургалт, цуврал уулзалтуудыг зохион байгуулах нь зүйтэй. Ингэснээр **нэг талаас сэтгүүлчдийн, нөгөө талаас хуулийн салбарын ажилтнуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх, түүний хэрэгжилтийн талаарх ойлголтын зөрүү арилах, хамтран ажиллах** зэрэг ач холбогдолтой.
- Ажил олгогч байгууллага ажилтантайгаа хөдөлмөрийн гэрээ хийхдээ “Сэтгүүлчийн аюулгүй байдал”-ыг хангаж ажиллахтай холбогдуулан аюулгүй байдал зөрчигдөхөөс хэрхэн сэргийлэх, зөрчигдсөн

тохиолдолд хэрхэн ажиллах тухай нарийн тодорхой тусгах хэрэгтэй. Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллага **ажилтнууддаа зориулсан аюулгүй байдлын баримт бичгийг бий болгож, даган мөрдөхийг** зөвлөж байна.

- Сэтгүүлчид болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай зөвлөмж, туршлагын талаар нийтлэл, нэвтрүүлэг бэлдэж түгээх нь энэ асуудлыг олны анхааралд аваачих, аюулгүй байдалдаа анхаарч ажиллахыг бусдад сануулах гол түлхэц болох юм.